

ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-48
1. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/	7-14
2. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	14-23
3. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 20 гишүүн 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/	24-40
4. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 11 гишүүн 2025.6.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/	40-44
5. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/	44-48

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Ёс зүй, дэгийн байнгын хорооны
06 дугаар сарын 30-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 49 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Батсуурь;
Чөлөөтэй: Ч.Лодойсамбуу, Д.Энхтуяа.

Нэг.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер Б.Лхагвацэнд, Б.Долгорсүрэн, И.Эрдэнэцэцэг, ахлах аудитор Д.Цэгмиддорж, П.Амарсанаа, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын ахлах аудитор У.Оюунхүү, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, Д.Рэгдэл нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн

*газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, **хоёр дахь хэлэлцүүлэг**, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер Б.Лхагвацэнд, Б.Долгорсүрэн, И.Эрдэнэцэцэг, ахлах аудитор Д.Цэгмиддорж, П.Амарсанаа, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын ахлах аудитор У.Оюунхүү, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, мөн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн, Д.Рэгдэл, Б.Баярбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 20 гишүүн 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, **анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Б.Мажигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Я.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа хариулж, тайлбар хийв.

Төслийн 4, 5, 6, 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Тав.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зургаа.Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 11 гишүүн 2025.6.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Б.Мажигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Б.Баярбаатар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл талаар:

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Б.Мажигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, Б.Хэрлэн нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Баярбаатар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 12 минут үргэлжилж, ирвэл зохих 12 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 19 цаг 01 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, Даваа гараг
Төрийн ордон “Их засаг” танхим, 16 цаг 49 минут

ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Баярбаатар: Ёс зүй, дэгийн байнгын хорооны сүүлийн хуралд хүрэлцэн ирсэн эрхэм гишүүддээ өдрийн мэндийг хүргэе. Ирц хүрсэн байна. Ирцийг танилцуулна.

Баярмагнайн Баярбаатар ирсэн байна. Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн ирсэн байна. Жамбын Батсуурь гишүүн гадаадад томилолттой. Даваасамбуугийн Ганмаа гишүүн ирсэн байна. Болдын Жавхлан гишүүн Эдийн засгийн байнгын хороон дээр байгаа. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн ирсэн байна. Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн Эдийн засгийн байнгын хорооны хурлыг даргалж байгаа. Ганбатын Очирбат гишүүн ирсэн байна. Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн байна. Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн байна. Доржзовдын Энхтуяа гишүүн чөлөө авсан байна. Хурал нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудал.

1.“Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/.

2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025 оны 6 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/.

3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа нарын 20 гишүүн 2025 оны 6 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/.

4.Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Хишгээгийн Тэмүүжин нарын 11 гишүүн 2025 оны 6 сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/.

5.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа нарын 9 гишүүн 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу. Алга байна. Болдын Жавхлан гишүүн ирсэн байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа орно. Ажлын хэсэг танилцуулна. Болдын Жавхлан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд, Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Цэдэвсүрэн Төрийн албаны зөвлөлийн дарга чөлөө авсан байгаа. Н.Ганбаатар Ёс зүйн хорооны ажлын албаны дарга, Б.Цогбадрах Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга байна уу. Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Лхагвацэнд Санхүү-нийцлийн аудитын газрын менежер, Гүррагчаа Ёс зүйн хорооны ахлах мэргэжилтэн, Сувд Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн. Ажлын хэсгийг танилцууллаа.

“Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийнэ.

“Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Болдын Жавхлан гишүүний микрофоныг өгье. Болдын Жавхлан сайдын микрофоныг өгөөрэй.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын чуулганы 6 дугаар сарын 23-ны нэгдсэн хуралдааны анхны төслийг танилцуулсан.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Төрийн албаны зөвлөлийн даргын багцын 2 төсөвт байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 6,7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, урсгал зардалд 6.7 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж төсвийн

тухай хуулийн дагуу “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Б.Баярбаатар: Сангийн сайд Болдын Жавхлан танд баярлалаа. Дараагийн танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Магнайсүрэн танилцуулна. Магнайсүрэн даргын микрофон. 3 номерын микрофон.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын талаар хураангуйлан танилцуулъя.

1.Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 3 тайлан нэгтгэснээс 2 байгууллагыг түүвэрт хамруулсан. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 14,8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0,6 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14,2 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсох 1 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 22,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тайлан тоонд санхүүжих 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан ба төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж, 86,4 хувийн санхүүжилтийг олгосон байна.

2-т нь Төрийн албаны зөвлөлийн даргын төсвийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 2 тайлан нэгтгэснээс 1 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 50,5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, аудитаар шалгасан нийцлийн аудитаар илэрсэн 580,6 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өглөө.

3.АТГ-ын даргын төсвийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн суурь захирагчийн санхүүгийн тайлан дүгнэлт гаргалаа. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй, харьяа 1 байгууллагад мөн өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 7,1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тайлан тоонд санхүүжих 1 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан ба төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж 92,1 хувийн санхүүжилтийг олгожээ.

Дээр дурдсан аудитын дүн, дүгнэлтээс үндэслэн дараах асуудлуудад анхаарлаа хандуулахыг санал болгож байгаа. Үүнд,

Төсвийг зохистой удирдаагүйгээс авлага, өр төлбөр үүсгэсэн, тооцоо нийлж баталгаажуагүй, хугацаа хэтэрсэн, эзэн холбогдогч нь тодорхой авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах;

2-т нь төсвийн ерөнхийлөн захирагчид худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах;

3-д нь аудитор тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, алдаа зөрчил давтан гаргахгүй байхад анхаарах зэрэг болно.

Ийнхүү санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаа үүгээр танилцуулж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Баярбаатар: Магнайсүрэн даргад баярлалаа. Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлантай холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө. Бадарчийн Хэрлэн гишүүнээр тасаллаа. Рэгдэл гишүүнээр тасаллаа. Бадарчийн Хэрлэн гишүүн.

Б.Хэрлэн: Тэгэхээр энд надад 2 асуулт байна. Эднийх чинь 30 жилийнхээ ойг тэмдэглэх гэж байгаа. Тэгтэл нөгөө зочин төлөөлөгч хүлээж авах энэ зардал энэ дээр 15 саяар төлөвлөгдөж байсныг нь сая тодотголоор хассан байна л даа. Тэгэхээр нөгөө 30 жилийн ой мэдээж хэрэг гаднын зочин төлөөлөгч ирэх байх. Тэгэхээр энэ зардлаа яах юм бол гэж. Гүйцэтгэл үү. Тэгвэл би гүйцэтгэл дээр юм байхгүй. Тодотгол дээр нь л байгаа.

Б.Баярбаатар: Ганбатын Очирбат гишүүн асуулт асууна.

Г.Очирбат: Өдрийн мэнд. Зарчмын ганц хоёрхон асуулт байна. Энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульдаа бид нар 2010 оноос хойш 19 удаагийн өөрчлөлт хийчхэж байгаа юм л даа. Тэгээд ер нь энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль чинь байх хэрэг байгаа юм уу, байхгүй юм уу. Тэгээд Жавхлан сайдаас байнга асуусаар байгаад тэгээд хариулт нь мэдэж байна гэдэг шиг. Ер нь энэ Тогтвортой байдлын тухай хуулиа мөрдөөд явах ёстой юм уу, явахгүй юм уу. Заавал одоо жишээ нь 2023 оны 5 сард батлагдсан хууль 2023 оны 11 сард, 2024 оны 8 сардаа 2 удаа ингээд өөрчлөөд орж ирээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ байдлаа ер нь цаашдаа бид нар яаж авч явах ёстой юм бэ гэдэг асуулт байна. Д

Дараагийнх нь асуулт. Тайлантай танилцаж байхад энэ татварын систем нь 1990 оноос хойш үүссэн 3,3 их наядын татварын өрийн үлдэгдэл байгаад байгаа юм. Тэгээд энийг ер нь цаашдаа яаж авч явах ёстой юм. Ингээд ер нь ингээд үлдээд л, нэмэгдээд л, жил болох тусам нэмэгдээд л яваад байх ёстой юм болов уу, үгүй юм болов уу. Аж ахуйн нэгж байсан бол энэ ч өнгөрлөө л дөө.

3 дахь нь болохоор бүгдээрээ л төсвийн зарлагын реформыг бид нар хийе гээд л ярьдаг. Тэгээд 2024 оны хувьд бол зөвхөн улсын төсвийн урсгал зардал 16 их наяд хүрч байгаа юм. Төсвийн зарлагын реформ. Бүгд тэгж ярьдаг шүү дээ. Ухаалаг төр, цомхон байя, төсвөө таная, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлье гээд л ярьдаг. Тэгээд энэ чинь 2024 оны байдлаар гэхэд чинь л 16 их наяд хүрчихсэн. 1996 оноос хойш 30 жилийн хугацаанд авч үзэх юм бол 162 тэрбум чинь 30 их наяд 591 болчихсон. 183 дахин нэмэгдчихсэн. Тэгэхэд ард иргэдийн амьдрал яг

энэ хувиар нэмэгдэж чадсан болов уу гэдэг 3 асуулт асуугаад тэгээд тодруулъя даа.

Аудитынхнаас бас асуулт байна. Манай аудитынхан ингээд тайлангуудаа дандаа ийм ерөнхий үгнүүдээр оруулж ирдгээр нь зогсоочихвол яадаг юм бэ. Яг ийм бол ийм, тийм бол тийм гээд явахгүй бол ерөнхий үг болгоны чинь ар талд 2 санаатай утга яваад байдаг. Тэгээд энэ тайлан дээр тэгж байгаа юм. Төсвийн төлөвлөлт нь улс төрийн нөлөө их байна гээд байгаа юм. Тэгээд улс төрийн нөлөө нь яг яаж нөлөөлөөд байгаа юм гэдгийг Үндэсний Аудитын газраас асууя. Ингээд тодруулъя.

Б.Баярбаатар: Сангийн сайд Болдын Жавхлан хариулна.

Б.Жавхлан: Очирбат гишүүний асуултад хариулъя. Таны 3 асуулт нь гүйцэтгэлтэй гурвуулаа огт холбоогүй юм байна гэж ойлголоо.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гүйцэтгэлтэй бол холбоогүй, зарлагын реформ гүйцэтгэлтэй холбоогүй, татварын өр төлбөрийг манай Татварын ерөнхий газрын дарга ороод ирэх байх. Дуудчихлаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль бол ер нь эдийн засгийн макро төлөвлөлтийн хууль шүү. Макро төлөвлөлтийн хууль. Шууд төсөвтэй бол холбоотой зүйл биш. Төсөвтэй холбоотой зүйл маань төсвийн суурь хууль. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль маань макро төлөвлөлт буюу ерөнхийдөө эдийн засгийн хүрээ, хязгаарууд маань ямар хэмжээнд байх вэ гэдгийг хязгаарлаж өгдөг ийм тоонууд. Тэгэхээр энийгээ өөрчлөх шаардлага гарвал өөрчилнө. Хэд ч өөрчилж болно шаардлага гарвал. Тийм хуультай. Их Хурлаас баталсан хууль маань өөрөө тийм хуультай. Нэлээн чагт хийчихсэн, хязгаар хийчихсэн. Одоо жишээ нь ингээд төлөвлөөгүй ийм орлогын хязгаарт ороод ирэхээр бид төсвийн хүрээгээ буюу макро төлөвлөлтөө хумиад, тэрнийхээ дагуу салбар хоорондоо зохицуулалт хийж, дахиж микро түвшинд хумилт хийх, төсөв дээрээ хумилт хийх, хэмнэлт хийх шат дараалал арга хэмжээнүүдийг аваад явж байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр шаардлагатай бол өөрчлөлт хийнэ. Энэ чинь Үндсэн хууль биш. Ийм чиглэлийн салбарын хууль. Макро төлөвлөлтөд ялангуяа уул уурхайгаас хамааралтай эдийн засагтай, хөгжиж байгаа орны хувьд бол макро төлөвлөлт хийх, маневр хийх, тэнцлээ сайжруулах ийм асуудлууд бол ер нь их гарна. Тэр болгонд бас өөрчлөх шаардлагатай бол өөрчлөөд л явна. Одоо ч гэсэн ноднин хийсэн өөрчлөлтийн дагуу бол зөрчил үүсчхээд л байна. 2025, 2026 оны төсвийн хүрээнүүдээ өөрчилж байж, 9 сарын 1-нд ирэх оныхоо төсвийг бид нар өөрчилнө. Сая хэдхэн сарын өмнө Гантөмөр сайд эдийн засгийнхаа хүрээг батлуулсан Их Хурлаас. Гэтэл тэрнээс чинь хойш 1 сарын дотор бүгд өөрчлөгдчихлөө. Төсөөлж байсан үнийн төсөөллүүд нь Гантөмөр сайдын төсөөлж байсан нүүрсний үнэ тэрнээс хойш уначихлаа. Оны эсрэг унахаар байна. Хойтон унахаар байна. Тэгэхээр 9 сарын 1-нд сая Гантөмөр сайдын өргөн барьж батлуулсан төсвийн хүрээгээр явах уу, үгүй юу. Энэ чинь тэгээд буцаагаад л Төсвийн тогтвортой байдлын хуулийн дагуу төсвийн хүрээнд өөрчлөлт оруулах л шаардлага үүсчхэж байгаа байхгүй юу. Дандаа л ийм л өөрчлөлтүүд.

Ковидын үед алдагдлын хязгаарууддаа бол багтаж чадахааргүй байсан. Тэрийг жигд хойшлуулсан 1 том өөрчлөлт тэр байгаа. Ийм байна.

Зарлагын реформ гэж байна. Зарлагын реформыг ярихын тулд 2024 онд 2025 оны хуулийг төсвийн хууль баталж байх үед дагасан тогтоол дотор бид нэг үүрэг авсан байгаа. Энэ зардлын реформд энэ маш олон хуулиудаар аль хэдийн төсвийн хуваарилалтыг төсөв төлөвлөхөөс өмнө хуульчилчихаад байгааг тэндээс бүх реформ эхлэх ёстой байгаа. Энийг Их Хуралд буцааж танилцуул гэдэг үүргийг бид нар авсан байгаа. Тэрнийхээ дагуу бид сая 4 сард 204 хууль дээр мянга гаруй заалтаар төсвийн хуваарилалт аль хэдийн хийгдчихээд байна. Бид нар эндээс зөвхөн 40 гаруй хувийг нь л төсөвт тусгаж чадаж байна. Цаана нь төсөвт багтахгүй 50 гаруй хувийг нь эзэлж байгаад төсвийн гадуур үлдчихсэн байгаа. Ингээд хаалга тогшоод зогсож байгаа. Яг зарлагын реформ, төсвийн реформ хийвэл яг тэндээс л эхлэхээр байгаа. Тэрийг бид нар ангилаад, эрэмбэлээд Их Хуралд өгөөд, Булгантуяа даргаар ахлуулсан ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Таныг байгаа шиг санаад байх юм. Тийм байгаа. Тэрийг одоо яг ангилаад л, эрэмбэлээд л, энийг нь боль, энийг нь хойшлуул, энэ нь гарцаагүй юм байна гээд эрэмбэлчих юм бол тэндээс хамгийн том энэ төсвийн .../минут дуусав/

Б.Баярбаатар: Микрофон өгчихье гүйцээгээд хариулчих. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Энэ удаа гишүүд маань бас энэ асуудлыг маш олон талаас нь хөндөж ярьж байгаа учраас би ирэх оны төсвөө өргөн барихдаа бол энийг өргөн барина гэж бодож байгаа. Сая бол тодотголоор арай амжсангүй. Ер нь бол бид нар бэлдчихсэн байсан. Хэрвээ тодотголоор өргөн барьсан бол тодотголоо хийж амжихгүй байх байх. Маш олон ажлын хэсэг гарч ирээд. Харин тэр үед салбар салбарын хамгаалагч, улаан хамгаалагч нар гарч ирээд, тэр зардлыг хасахгүй, энэ зардлыг хасахгүй, энийг авч үлдэх ёстой, энэ халамжийг энэ тухайн салбарын халамж байх ёстой, энэ нэмэгдлүүд байх ёстой, эвий чааваас гээд бүгд ингээд хамгаалагч болоод тараад гүйчихдэг юм шүү. Ингэж болохгүй шүү. Та тэр үед бас зоригтой байгаарай. Нэлээн том жагсаалт орж ирж, намаржингаа ийм том хэлэлцүүлэг болох байх. Сая бол ганцхан төрийн албаны тухай хууль л оруулж ирсэн. 42 хууль бэлдчихсэн байсан оруулах гээд. Тэгээд өмнөх өдөр нь болиод ганцхан хууль л оруулж ирсэн.

Б.Баярбаатар: 4 номерын микрофонд Магнайсүрэн дарга хариулна.

С.Магнайсүрэн: Очирбат гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт энэ тайлан ерөнхий байна гэдэгтэй холбогдуулаад жишээлбэл тэр улс төрийн нөлөө төсвийн төсөлд бас нөлөөлөл байна гэсэн энэ агуулгаар та асуулаа. Бид нар энэ 2024 оны тайлангийн онцлог болохоор зэрэг сонгуультай жилийн ийм тайлан байгаа. Тэгэхээр өмнөх 3 жилтэй нь харьцуулаад Үндэсний Аудитын газраас дүгнэхэд 1,5-3,3 дахин энэ зардлууд өссөн ийм үзүүлэлттэй байгаа. Тэгээд тэрийг нь харах юм тийм амлалтын чанартай гэдэг юм уу ийм шинж нь давамгайлж байна. Тэгээд энэ өсөлт нь дараагийнхаа 4 жилдээ бас нөгөө зардал дээрээ ийм үр ашигтай байх төсвийн зорилгод нийцэхгүй байна гэсэн ийм байдлаар дүгнээд, энийгээ сонгуульт мөчлөгөөс хамаарсан ийм улс төрийн шинжтэй нөлөө байна гэж ингэж дүгнэсэн байна лээ. Тэгээд энийгээ би .../минут дуусав/

Б.Баярбаатар: Татварын Ерөнхий газрын дарга. Ажлын хэсгийн микрофон дээр оччих. 5 номер дээр очоод суучих.

Ч.Чимидсүрэн: Татварын ерөнхий газар Чимэдсүрэн. Гишүүний асуултад хариулъя. Өрийн талаар бид нар он гараад нэлээдгүй эрчимжүүлсэн төлөвлөгөө гаргаад, тусгай өр барагдуулах комисс гаргаад ажиллаад явж байгаа. 2024 оны эцсийн үлдэгдлийн өр 3.9 байсан. Гэхдээ өр гэдэг маань бол нөгөө татварын тайлангаа илгээгээд ноогдол үүсчихээрээ л өрийн хөдөлгөөнүүд бол ингээд явчихдаг. Тэгээд зарим татварын төрөл маань сард тайлагнадаг, улирлаар тайлагнадаг, жилийн эцсээр тайлагнадаг учраас бол энэ тоонууд бол нийлээд явдаг. Ингээд түүнээс хойш бид нар 1,4 их наядын хуримтлагдсан өрийг барагдуулсан байна. Яг сүүлийн 4 сард өгсөн Сангийн сайдын үүрэг чиглэлийн дагуу 200 тэрбумын хуримтлагдсан өр төлөгдсөн ийм хэлбэртэй явж байгаа.

Гэхдээ өр нь өрнүүдийн нийт үлдэгдэл бол ингээд 4 их наяд гэсэн үг шүү дээ. Энэ дотроос бас яг нарийвчлаад ангилаад үзэх юм бол нэлээн хүндэрчихсэн буюу 3, 4 жилээс дээш тэр нь бол бас 1.4 .../минут дуусав/

Б.Баярбаатар: Тодруулах уу Очирбат гишүүн.

Г.Очирбат: Тэгээд 1 л юм харагдаад байна л даа. Хэцүү юм даа нээрээ. Тэгээд юм ярихаар улс төржчихсөн болчих гээд байдаг. Төлөвлөж чадахаа больчихсон. Гадна, дотнын нөхцөл байдал, геополитикийн асуудал гэдэг энэ бол тооцох л ёстой асуудал. Манай мэргэжлийн яамнууд олон мэргэжлийн боловсон хүчин байдаг тооцоод л ажиллах ёстой байсан. Гүйцэтгэж чадахаа больсон. Мөнгөө үрж чадахаа больсон. Мөнгөө үрж чадахаа болиод 530 хэдэн тэрбумыг татуулж байгаа. Тиймээ Жавхлан сайд аа, тендерээ зарлаагүй, хуулиа хэрэгжүүлээгүй, хуулийн хугацаанд мөнгө нь татагдаж байгаа. Мөнгөө үрж чадахаа больсон зовлон нь. Тэгээд дүгнэлт боловсруулж чадахаа больчихсон. Хууль, эрх зүйн хоорондын чиг үүргийн уялдаа холбоо хангагдахаа байсан. Аль хууль нь алийгаа яаж хамаараад, ямар чиг үүргийг хэрэгжүүлэх юм мэдэхээ больчихсон. Дуртайгаараа оруулж ирээд өөрчлөөд байгаа .../минут дуусав/

Б.Баярбаатар: 1 минут нэмж өгье. Очирбат гишүүнд.

Г.Очирбат: Тэгээд энэ байдлаа л хэдүүлээ 126-уулаа нийлж байгаад л өөрчилье. Жавхлан сайд түрүүн таны хэлж байгаа санааг чинь бас ойлголоо. Зоригтой байгаарай гээд. Тэр Төрийн албан хаагчийн тухай хууль дээр бол орж ирээд явчих ёстой байсан шүү дээ. МАН-ын бүлгээр ороод л татуулчхаж байгаа шүү дээ. Тэгээд дандаа манай МАН-ын залуу гишүүд бид нар бүгдээрээ сууж байна шүү дээ. Тэгээд зарим нэг юмыг зоригтой хийгээд эхлэхгүй бол болохгүй. Одоо Булгантуяа даргын ахалж байгаа ажлын хэсэг дээр олон асуудлууд байгаа. Олон хуулийн давхцалууд. Тэгээд хойно нь дандаа тэр нийгмийн халамжийн асуудлууд, салбарын асуудлууд ярьдаг. Тэгээд л ёстой түрүүний Жавхлан сайдын хэлдгээр 1, 1 уриа лоозон бариад л ороод ирэх байх л даа. Тэгээд энэ намар энийгээ хамтдаа туулъя Жавхлан сайд аа, тэгэх үү. Тэгээд жоохон зоригтой үзье. Энэ улс эх орноо жоохон өөр болгохгүй бол нөхцөл байдал хүндэрчихсэн байна гэдэг чинь өдөр болгон харагдаж байна. Сүүлдээ бол би ингээд асуулт асуух, үг хэлмээр ч үгүй болж байгаа юм Баярбаатар дарга аа. Асуугаад ч нэмэр байхгүй, хэлээд ч нэмэр байхгүй, зүгээр л нэг ийм .../минут дуусав/

Б.Баярбаатар: Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууна.

Д.Рэгдэл: Баярлалаа. Энэ 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл хараад байхад төсөв хэмнэлт ялангуяа бид нартай хамааралтай энэ салбар дээр их гардаг юм байна. Энэ чинь урсгал зардал шүү дээ зөвхөн. Бараг 12 хувь нь 2024 оны байдлаар Төрийн албаны зөвлөлийн төсвийн хэмнэлт болчихдог. Энэ яаж төлөвлөхөөрөө энэ их мөнгийг тавиулж авчхаад, баралгүй ингээд буцаагаад тушаачихдаг юм бол. Энэ зөвхөн урсгал зардал дээр ч биш, ер нь улсын хэмжээний Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангаас ч юм уу, энэ төсвийн гүйцэтгэлээс харахад улсын хэмжээнд энэ чинь үндсэндээ бараг 1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хэмнэгдчихсэн байгаа юм. Хийгдээгүй. 1 их наяд төгрөг. Энэ чинь бол асар их мөнгө байгаад байдаг. Энэ яагаад хэмнэгдээд байдаг юм. Ингээд төлөвлөхөөд, мөнгөө бичүүлж авчхаад гүйцэтгээгүй, ажлаа гүйцэтгээгүй, төсвөө ашиглаагүй үлдээчихсэн хүмүүст ер нь аудитын зүгээс ямар арга хэмжээ санкц зөвлөж өгдөг юм. Манай Засгийн газар ямар хариуцлага тооцдог юм. Дараагийн төсвийн төлөвлөхдөө төсвийн төлөвлөгөө гаргахдаа энэ бүхнийг ер нь харгалзаж үздэг юм болов уу, үгүй юм болов уу гэсэн асуулт байна.

Б.Баярбаатар: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Аудит хариулахгүй юм уу. Төрийн албаны зөвлөлийнхөн байна уу. Төрийн албаны зөвлөлийн энэ гүйцэтгэлийнхээ дүнг тайлбарлачхаач дээ. Дарга нь ирээгүй юм уу. Уг нь яг энэ гүйцэтгэлээ бол дарга нь өөрөө л яривал зүгээр дээ.

Б.Баярбаатар: Төрийн албаны зөвлөлөөс хүн байна уу. Цэдэвсүрэн дарга бол гаднын зочинтой явж байгаа гээд чөлөө авсан. Чухал асуулт асуулаа шүү дээ.

Б.Жавхлан: Би хэлчихье. Ер нь бол манай төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр нийтлэг гардаг зүйл. Хөрөнгө оруулалт дээр харилцан адилгүй ийм гүйцэтгэлүүд гараад байдаг юм. Ер нь маш олон жилийн дунджаар ер нь 85-90 хувьтай гардаг ийм байгаа. Энэ жил нэлээн өндөр гарна. 90-ээс дээш гарах байх. Яагаад гэвэл нөгөө хийж чадахгүй байгаа юмнуудыгаа сая хураалгачихсан. Ер нь жилийн эцэс рүүгээ 6 сараас хойш сүүлийн хагаст л төндөр нь арайхийж дуусаад л, гэрээгээ хийгээд, бараг 8, 9, 10 сард ажил нь эхэлсэн нь тухайн жилдээ гүйцэтгэл нь муу гараад, жилийн эцэс рүү арайхийж тавиулсан мөнгөө дутуу авдаг. Энэ жил бол ингээд 6 сар гэхэд гэрээ хийж амжаагүй нь татагдчихаж байгаа учраас хугацааны хувьд бол эхний 5 сардаа ажил нь эхэлчихсэн ажлууд бол оны эцсээр гүйцэтгэл сайн гарна. Тэгэхээр энэ 5 сарын 31-ний төрийн хэмнэлтийн цаг хугацааны хязгаарыг битгий өөрчлөөсэй. Энэ ингээд яваасай. Энэ нэлээн сахилга баттай явахад их зүгээр хугацаа байна гэж харж байгаа.

Урсгал дээр яг төсвийн ерөнхийлөн захирагч өөрөө энэ дээр хариулах хэрэгтэй. Одоо жишээ нь энэ 894 тэрбум төгрөг гэдэг чинь бараг тэрбум төгрөгийн ийм хэмнэлттэй гарсан байна. Энэ бодвол тухайн байгууллага дээрээ төлөвлөж байсан, энэ жил эхлүүлнэ гэж байсан ч юм уу олон улсын төсөл хөтөлбөр биш, өөрийнхөө сайдын багц дээрх зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх байсан тэр юмнууд нь хэрэгжээгүй байдаг ч юм уу ийм байдлаар л хэмнэлтүүд гарсан байх учиртай. Тэгээд тайлбарлачихмаар байна.

Б.Баярбаатар: Ажлын хэсгийн микрофон 4 номер дээр очоод суучих. Өөрийгөө танилцуулаарай.

Н.Мөнхсүх: Би Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Мөнхсүх гэж хүн байна. Гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны зөвлө бараа, үйлчилгээний бусад зардлаас 181 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 66,1 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 114 сая төгрөгийг тус тус хэмнэсэн. Шалтгаан нь гэх юм худалдан авах ажиллагаа болон байгууллагын сургалтын төлөвлөгөөг нэмэлтээр батлаагүй зэрэг шалтгаанаас үүссэн. Мөн тэтгэвэрт гарахад нь олгох 1 удаагийн тэтгэмжийн зардал тайлан тоонд 1 хүн тэтгэврийн тооцоолол үүссэнээс 59,3 сая төгрөг хэмнэсэн байна. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжаас 132,7 сая төгрөг хэмнэгдсэн. Байр ашиглалтын үйлчилгээний гэрээний хэмнэлтээс 67,9 сая төгрөг. Мэдээлэл технологийн үйлчилгээний цогц чадамжийн хүрээнд ур чадвар шалгах шалгалтын асуулт гэсэн ийм ажил байгаад, энэ нь 2 удаа тендер зарлаад амжилтгүй болсноос ийм хэмнэлт үүссэн байна.

Б.Баярбаатар: Рэгдэл гишүүн тодруулна.

Д.Рэгдэл: Тэр хүснэгт чинь ч бид нар дээр байна л даа. Тэгэхээр бид нар харж байна энэ тоог. Гэтэл яагаад жишээлбэл цалин хөлснөөс үндсэндээ нийт хэмнэгдсэн мөнгөний чинь 50 хувь цалин хөлснөөсөө хэмнэгдчихэж байгаа юм. Тэгэхээр энэ чинь бид нар юу гэж бодох вэ гэхээр мэдэхгүй хүмүүс дутуу орон тоогоор ажилладаг юм уу, эсвэл хүмүүстээ цалинг нь гүйцэд өгдөггүй юм уу гэсэн юм бодоод байна шүү дээ. Энэ цалингаас ингэж их хэмнэгдэх бол ер нь сэжигтэй. Энэ худлаа төлөвлөлт байдаг юм уу.

Б.Баярбаатар: Хариулах хүн байгаа юу энэ дээр. Асуудлыг хойшлуулдаг юм уу. Өнөөдрийн 2 асуудлыг хоёуланг нь. Төрийн албаны зөвлөл иртэл. Дараа нь Төсвийн тодотгол хэлэлцэнэ. Төрийн албаны зөвлөл бас байхгүй. Үгүй ээ, ингэж хэлэлцсэнээс хойшлуулсан нь дээр байх. Дараагийн 7 хоног руу орно гэсэн үг шүү дээ. Уг нь яг ингэж хэлэлцмээргүй л байгаа юм. Чухал чухал асуудлууд байдаг. Тэгээд өнөөдөр манай Ёс зүй, дэгийн байнгын хорооны сүүлийн хурал явж байна.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

“Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ. Аюушийн Ариунзаяа гишүүн танилцуулна. Нэг дэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

17.19 цаг.

Дараагийн асуудалд орно.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

Засгийн газар 2025 оны 6 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулъя. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Ажлын хэсэг байна уу. Болдын Жавхлан Сангийн сайд, Н.Ганбаатар, Ёс зүйн хорооны ажлын албаны дарга, Цогбадрах Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Лхагвацэнд Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Лхагвацэнд сууж байсан яагаад гараад явчлав. Зэрэг хуралдаад байна уу.

Санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн төслийн танилцуулгыг, Монгол Улсын Ерөнхий аудитор төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд танилцуулна гэж заасны дагуу Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулгаа хийнэ. Сангийн сайд.

Б.Жавхлан: Эрхэм байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхий дахинд үүсээд буй сорилт бэрхшээлийг Монгол Улсын эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, мөн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.1.4 дэх заалтын дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголын төслийг боловсруулж, 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Эдийн засгийн сорилт хүндрэлийг даван туулахад төсвийн сахилга бат, үр ашигтай зарцуулалт онцгой чухал үүрэгтэй. Тиймээс хэмнэлтийн тодотголд бүх шатын төрийн байгууллагуудын тэвчиж болох зардлыг хэмнэх зарчмыг баримтлалаа. Цомхон, бүтээмжтэй төртэй байхын тулд төрийн албаны орон тоог 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн 9 хувиар бууруулахаар тооцлоо.

Мөн төсвийн байгууллагын тээвэр шатахуун, дотоод албан томилолт, хичээл, үйлдвэрлэлийн зардал, төрийн өндөр дээд айлчлал болон өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албанд томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, тавилга, эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх болон багаж техникийн зардал, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад олгодог татаасны зардал, байгууллагаас олгох 1 удаагийн болон бусад төрлийн тэтгэмж, урамшуулал, хөтөлбөр, арга хэмжээний зардал зэргийг хэмнэхээр тооцож холбогдох өөрчлөлтийг тодотголын төсөлд тусгалаа.

Төрийн албаны зөвлөлийн даргын багцын төсөв 2025 оны батлагдсан төсвөөс нийт зардал 4,3 тэрбум төгрөгөөр буурсан. Мөн багцын хэмжээ нь 7 орон тоо буурч 78 орон тоотой байхаар тооцлоо. Төрийн албаны зөвлөлийн төсөв 2025 оны батлагдсанаас төсвөөс нийт зардал 3,5 тэрбум төгрөгийг бууруулахыг төлөвлөж, тус байгууллагын төрийн албан хаагчийн тоог 9 хувиар буюу 5 орон тоотойгоор бууруулж, 56 орон тоотой байхаар тооцлоо.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хорооны ажлын албаны төсөв 2025 онд батлагдсан төсвөөс нийт зардал 0,8 тэрбум төгрөгийг бууруулахаар төлөвлөж, тус байгууллагын төрийн албан хаагчийн тоог 9 хувиар буюу 2 орон тоогоор бууруулж, 2 орон тоотой байхаар тооцлоо.

Ийнхүү 2025 оны төсөвт тодотгол хийснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3 их наяд 260 тэрбум төгрөгөөр бууруулж, 30 их наяд 209 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг 1 их наяд 856,5 тэрбум төгрөгөөр бууруулж, 31 их наяд 575.1 тэрбум төгрөгт хүргэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 365,2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1,5 хувийн алдагдалтай болж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Баярбаатар: Сангийн сайдад баярлалаа. Хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг Магнайсүрэн дарга танилцуулна. 4 номерын микрофон.

С.Магнайсүрэн: Монгол Улсын Их Хурлын Ёс зүйн, дэгийн Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 сарын 25-ны өдөр Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хийж гүйцэтгэлээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах 3 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт төвлөрүүлэх орлогыг өмнөх оноос бууруулахгүй, зарлагыг 14,3 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөжээ. Байнгын хороо энэхүү хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэхдээ дараах асуудалд анхаарал хандуулахыг санал болгож байна. Үүнд,

Төрийн албан хаагчдын тоог чиг үүргийн давхардал, ажлын байрны ачаалалд бүрэн шинжилгээ хийлгүйгээр нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын орон тоог жигд 9 хувиар бууруулахаар тооцсон төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлж болзошгүй байна. Иймд төсвийн ерөнхийлөн захирагчид өөрийн хариуцсан салбартаа чиг үүргийн шинжилгээ, ажлын байрны ба бүтээмжийн үнэлгээ хийсний үндсэн дээр ажлын ачааллыг оновчтой хуваарилах зорилгоор харьяа байгууллагуудынхаа орон тоонд зохицуулалт хийх боломжийг олгох асуудлыг судлах,

2-т нь төсвийн тодотголтой хамт Их Хуралд өргөн барьсан тогтоолын төсөлд 2025, 2026 оны төсвийн жилд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаалын орон тоо бий болгохгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулах зэргээр цалин хөлсний зардлыг хэмнэх гэж заасан.

Энэ нь чиг үүргийн судалгаа хийсний үндсэн дээр ажлын ачааллыг нягтруулж, орон тоогоо зорилтот түвшнийг хүртэл нэгэнт бууруулсан байгууллагуудад сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх нь тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь сөргөөр нөлөөлж болзошгүй байх эрсдэлтэй байна.

3-д нь төсвийн ерөнхийлөн захирагч нарын сул орон тооноос бусад цомхотголд орж буй албан хаагчдад төрийн албаны тухай хуульд заасны дагуу ажлаас чөлөөлөгдсөний 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний 1 удаагийн тэтгэмжийн зардал шаардагдахаар байгааг энэ хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад хамтад нь шийдвэрлэх гарц шийдлийг олох.

Дээрх саналуудаас гадна төсөвт тодотгол хийх нөхцөл байдал үүссэн тохиолдолд аудитын байгууллагаас аудитын үйл ажиллагааны үе шатын стандартын дагуу хянаж, дүгнэлт гаргахад цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байгаа тул Төсвийн тухай хуульд энэ талаар Улсын Их Хуралд хүргүүлэх зохистой хугацааг тогтоож өгөх шаардлагатай байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэснээ үүгээр танилцуулж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Баярбаатар: Магнайсүрэн даргад баярлалаа. Танилцуулгатай холбоотой, хуулийн төсөлтэй холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө. 2 гишүүн байна. Рэгдэл гишүүнээр тасаллаа. Хэрлэн гишүүн.

Б.Хэрлэн: Тэгэхээр түрүүний Рэгдэл гишүүний асуултыг би үргэлжлүүлээд асуучихъя. Тэгэхээр 2024 онд цалин хөлсний зардал хэмнэгдэж байсан юм байна. 424 сая 100 мянгаар хэмнэгдэж байсан. Гэтэл 2025 онд цалин хөлсний зардал өмнөх онтойгоо харьцуулах юм бол ингээд 2 дахин нэмэгдээд ороод ирэх юм. Эдний орон тоо 1 дахин өсчихсөн юм болов уу. Хийх ажлынх нь цар хүрээ 1 дахин өсчихсөн юм болов уу. Яасан юм бол. Энийг 1 дүгээрт тодруулмаар байх юм.

2 дугаарт Магнайсүрэн дарга бодвол 2024 онд Үндэсний аудитын газраас Төрийн албаны зөвлөлийн талаар хийсэн тайланг уншсан байгаа байх. Тэгээд тэр дээр ер нь энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ, ялангуяа энэ дотор туссан байгаа тэр мэдээллийн технологийн үйлчилгээний зардал энд болохоор бол 4 тэрбум 185.8 гээд ингээд ороод ирсэн байна л даа. Тэгээд танай тайлан дээр юу гэж бичсэн байсан бэ гэхээр 2017 оноос хойш 4 удаа нийтдээ 1,3 тэрбум төгрөг зарцуулаад, хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгох ийм төсөл хөтөлбөрт зарцуулсан байна гээд бичсэн байгаад байсан. Тэгээд энэ бодвол тэр нь юм байлгүй дээ. Мэдээллийн технологийн үйлчилгээ гэсэн чинь бүр өмнөх оноосоо 4,4 дахин өсөж, энэ дүн орж ирсэн байх юм. Тэгэхээр энэ өмнөх танай тайлантай уялдуулаад та бүхэн энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ, ялангуяа мэдээллийн технологийн үйлчилгээ гэсэн энэ хэсэг дээр ерөнхийдөө анхаарсан уу, үгүй юу.

2 дугаарт нь, би бас Төрийн албаны зөвлөлийн 205 оны төлөвлөгөө дээрээс харахад бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр нь өмнөх оноос 6,8 дахин нэмэгдээд орж ирээд байгаа. Бид нар чинь нөгөө төрийн албан хаагчдынхаа тоог цөөлнө цөөлнө гээд байгаа. Гэтэл яг үндсэндээ нөгөө бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төсөв зардал чинь улам нэмэгдээд байгаа шүү дээ. Тэгэхээр төрийн албан хаагчид нь ажлаа хийж чадахгүй, өөр бусад хүмүүсээр хийлгэх хэрэгтэй болчихоод ингээд байна уу. Эсвэл угаасаа төрийн албаны ажил үйлчилгээ нь өөрөө нэмэгдчихээд, тэгээд яах аргагүй хувийн хэвшлээс өөр бусад гаднаас бас ийм ажил, үйлчилгээгээ хийж гүйцэтгүүлээд байдаг юм болов уу. Энэ ямар учиртай юм бол гэж би тодруулж асуумаар байна.

Б.Баярбаатар: Энэ дээр хэн хариулах вэ. Байхгүй. Төрийн албаны зөвлөл нь байхгүй. Энэ чинь гол хариулах ёстой байгууллага нь Төрийн албаны зөвлөл шүү дээ. Сангийн сайд хариулахгүй. Аудит хариулахгүй. Жавхлан сайд хариулах гээд үзэх үү.

Б.Жавхлан: Манай сайдаар ажиллаж байсан, төсвийн ерөнхийлөн захирагч хийж байсан, аймгийн дарга нар байсан. Ер нь төсөв барьдаг байсан хүмүүс ер нь энэ талаар их сайн мэдээлэлтэй байх учиртай. Ер нь хүний нөөцийн бол нэлээн нөөцтэй яваад байдаг юм. Ингээд энэ жил 7 сарын 25-нд сайд нараас төсвийнхөө хязгааруудыг Сангийн яам дээр ирүүлнэ. Бид ингээд 1 тоо өгсөн байдаг. Бидний өгсөн тоо чинь бол Их Хурлаас 2026 оны төсвийн хүрээгээ баталчихсан байгаа. Хүрээнийх нь дотор нь багтаагаад сайд сайд нар дээр хязгааруудаа тавиад өгдөг. 25-нд тэр хязгаартаа багтаагаад уг нь тоонуудаа ирүүлэх ёстой. Гэтэл ер нь тэр ирж байгаа тоо маань ер нь энэ хязгаартаа багтаж ирдэггүй. Ер нь 2-3 дахин том ирдэг. Тэрийг тэгээд яаж ийгээд Засгийн газар дээр ярилцаж байгаад л багтаад байна. Тэр дотор ер нь хүний нөөцийн бол 4-5 хувийн нөөц, ялангуяа хүчний байгууллагууд дээр бол заримдаа бүүр 5, 6 хувийн нөөцтэй явдаг ийм практик байдаг юм. Тэрийг яах вэ, энэ удаагийн төсвийн жилийн дундуур тодотгол хийж байгаатай уялдуулж 9 хувиар гэж байгаа маань ер нь бас энэтэй холбоотой юм шүү. Ер нь бол 4-5 хувийн нөөцтэй явдаг учраас энийгээ шууд танана. Тэгэхээр тооцоо яг тэгж гарч ирээд байгаа байхгүй юу. 14 мянгаас одоо яг систем дээр харагдаж байгаа нь 6700 сул яваад байгаа. Тэгээд сул явж байгаа гэдэгтэй автомат шууд бүгдийг нь хүн аваагүй гэж хэлж болохгүй. Нөгөө жирэмсний, түр амралттай энэ тэр чинь бас сул харагдаж байдаг. Энэ дээр үнэлгээнүүд хийгдээд, тэгээд сайд нар тэр сул орон тоогоо эхний ээлжид шахчихна. Тэгэхдээ 9 хувийн орон тооны хэмнэлтээр төсвийг нь энэ удаа тодотголоор таначхаж байгаа учраас хэрвээ орон тоогоо танахгүй гэвэл бусад зардлаасаа сайд өөрөө таналтаа хийгээд явах ёстой. Тийм үүрэг шууд авч байгаа. Энэ их хатуу үүрэг авч байгаа. Тэгэхээр сул орон тоотой нөөцтэй явах бол цаашаагаа нэлээн шавхагдана. Ингээд сая бид нар нөгөө эдийн засгийнхаа төлөвлөгөөгөө батлахдаа 9 хувь гээд оруулчихсан учраас хойтон нөгөө орон тоогоо шахаж чадаагүй үлдэгдлээ хойтон шахна. Тэгэхээр энийг бол сул орон тоотой явуулбал нэлээн шахагдаад явна.

Тэгэхээр мэдээж яг эндээ тулаад ирэхээр төсвийн ерөнхийлөн захирагч, сайд нар маань бол энэ чинь бас шууд хүний түрийвчинд хүрэхээс илүүтэйгээр орон тооны давхардал юу байна, цахимжуулалтаар шийдэх асуудлууд юу байна. Эсвэл нөгөө бусдаар гүйцэтгүүлэх буюу хувийн хэвшлээр хийлгүүлэх ямар ажил үүргүүд байж болохоор байна, тэрийгээ орон тоогоо цомхотгоод тийш нь шилжүүлэх ч юм уу иймэрхүү ухаалаг зохицуулалтууд руугаа сайд нар бол гарцаагүй орж таарна. Тэгэхээр бид нар ингээд төсвөөр нь шахаад оруулна л гэсэн үг.

Ер нь бусдаар гүйцэтгүүлэх гэдэг маань тэр. Өү Си Ти-ийн нөгөө нягтлан бодох бүртгэлийн журмаар бол purchase service and goods гэдгийг л бид нар тэгээд орчуулчихаар янз бүрээр ойлгоод байгаа юм. 2 талтай ойлгоод байгаа юм. Тэрнээс биш энэ чинь бол яг хувийн хэвшлээр гүйцэтгүүлж байгаа гэрээт ажлууд гэсэн үг.

Хэрвээ тэрийг төр өөрөө гүйцэтгэнэ гэвэл тэр хэмжээний орон тоо нэмнэ л гэсэн үг. Хэрвээ цаашаагаар төр өөрийнхөө үйл ажиллагаа, үйлчилгээг хувийн хэвшлээр хийлгэнэ гэвэл гарцаагүй энэ зардлууд бас тодорхой хэмжээнд нэмэгдэж таарна. Харин тэрийг нь илүү их тохиромжтой, салбар салбараар нь нэршлүүд нь, эдийн засгийн ангиллуудыг нь өөрчлөх ийм л чиглэл барихгүй бол энэ бусдаар гүйцэтгүүлэх гэдэг энэ нэршлээр нь бол хүлээж авах шинжгүй болоод байх шиг байна. Уг нь бол хувийн хэвшлээр хийлгүүлъя. Төр данхайгаад байна гэсэн мөртөө яг хувийн хэвшлийн бүлгээрээ хийлгүүлэх гэхээр үгүй ээ, энэ зардал чинь таалагдахгүй байна гээд. Тэгээд зардалгүйгээр мөнгө төлөхгүйгээр хувийн хэвшлээр үнэгүй хийлгүүлнэ гэж байхгүй шүү дээ. Тэгэхээр иймэрхүү бас зовлонгууд байгаа. Тэгэхээр ямар ч байсан ирэх жилээс тэр сул орон тоо бол нэлээн цэгцрэх ийм төсвийн хөшүүрэг рүүгээ бид орж байгаа гэсэн үг шүү.

Уг нь яг төсвийн шууд захирагч нь өөрөө байсан бол нэлээн амьдралтай ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Хэрлэн гишүүн тодруулна.

Б.Хэрлэн: 1 тодруулах зүйл байна. Тэгэхээр ер нь энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж 2025 онд 7 тэрбум 540 сая гээд ороод ирчхэж байгаа юм. Төрийн албаны зөвлөлийн яг нөгөө хөдөлмөрийн зардал буюу яг нөгөө цалин хөлсний зардлаас нь 1 тэрбумаар илүү хэмжээгээр тавигдаад ороод ирчхэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ юу гэсэн үг вэ. Энэ ер нь бол бид нар чинь бас яг хүний нөөцийн бодлого дээрээ арай алдчихаад байгаа юм биш биз дээ гэсэн нэг ийм бодол эндээс төрж байна л даа. Тэгээд би Сангийн сайд Жавхлан сайдаас бас ер нь бол бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж гэдгийг маш сайн тодорхой ангиллынх нь хувьд тодорхой зааж өгөхгүй бол жишээлэх юм бол энд бусдаар гүйцэтгүүлэх бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж гэхэд л 3 тэрбум 329 сая гээд л тавьчихсан хэр нь яг энэ ангилал дотор нь явж байснаа тээврийн хэрэгслийн оношилгоо 100 мянган төгрөг гэх жишээтэй, тээврийн хэрэгслийн татвар юу гэдэг юм 500 мянган төгрөг энэ тэр гээд л ингээд тавьчихсан байгаа байх. Бүр ийм харилцан адилгүй. Яахаараа энэ том дүнгээр тавигдаж байгаа бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний .../минут дуусав/

Б.Баярбаатар: Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Хэрлэн гишүүний асуултад хариулъя. Танилцуулгад яг бусдаар гүйцэтгүүлэх ангилал гээд ерөнхий ангиллаар нь тавьчихсан байгаа. Ингээд задлаад харах юм бол энэ чинь нийтдээ хэдэн төрлийнх байдаг билээ. Эдийн засгийн ангиллаараа дотор нь задлахаар бусдаар гүйцэтгүүлэх зардал чинь бүх төсвийн .. биш ээ, ангиллыг яриад байна шүү дээ. Эдийн засгийн ангилал. Нийт нийт сайд нарынх ороод одоо жишээ нь Төрийн албаны зөвлөлийн даргын тэр бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ дээр нь хэдэн ангилал байна. Систем дээрээсээ харчих л даа. Жишээ нь Төрийн албаны зөвлөлийн дарга бол

харьцангуй бага төсөвтэй бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээнийх нь дүн нь бас харьцангуй бага. Ингээд 7 ... /минут дуусав/

Б.Баярбаатар: Сангийн сайдын микрофоныг үргэлжлүүлээд өгчих. Гүйцээгээд хариулчих.

Б.Жавхлан: Нийт 37, 40 гаруй, 42 төсвийн ерөнхийлөн захирагч нарын бусдаар гүйцэтгүүлэх ангилал нь бол яг задалсан ангилал нь бол 1 мянга гаруй үйлчилгээний эдийн засгийн хөнгөлөлтийн төрлүүд данс болгоноороо байж байдаг юм шүү. Тэрийг харъя гэвэл системээс татаад харж болно. Энд оруулж ирэхдээ тэр чинь бөөн дүнгээрээ л орж ирсэн байгаа. Ийм зүйл байгаа. Тэр 7-г бол дахиж цааш нь задлах бол боломжгүй биз дээ. Батмөнхөө тэр 7-г нь уншаад танилцуулчих даа.

Б.Баярбаатар: 6 номерын микрофон дээр очиж сууж байгаад танилцуулъя.

Э.Батмөнх: Сангийн яам Батмөнх. 6 бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зориулалтыг уншиж өгье. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж, аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох даатгалын үйлчилгээ, тээврийн хэрэгслийн татвар, тээврийн хэрэгслийн оношилгоо, мэдээллийн технологийн үйлчилгээ, улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх.

Б.Баярбаатар: Бид нарт тараагдсан л байна л даа. Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: Баярлалаа. Ер нь би бас энэ бусдаар гүйцэтгүүлсэнтэй холбогдуулаад байгууллагууд бүр янз бүр байгаа юм. Шинжлэх ухааны байгууллага дээр бол тоног төхөөрөмж муу учраас гадаадад шинжилгээ хийлгэдэг төлбөр зардал гээд явчихдаг. Зүгээр энэ байгууллага чинь шинээр байгуулагдсан юм болохоор аваачаад мэдэхгүй, сайн мэдэхгүй юм. Тэгэхдээ би Төрийн албаны зөвлөлөөс хоёрхон юм асууя гэж бодоод байгаа юм. Энэ төсвийн тодотголыг дагуулаад, өргөн барьсан хуулиуд байгаа. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна гээд. Энэ хуулийн төсөл бол үндсэндээ төрийн албан хаагчдынхаа эсрэг баахан юм биччихсэн. Тэр байтугай одоогоос 7, 8 жилийн өмнө төрийн албаны тухай хуульд явж байгаад ерөөсөө болохгүй заалт байна гээд хасагдчихсан заалтуудыг нь буцаагаад сэргээчихсэн. Үндсэн цалингийн 40 хувиас хэтэрч болохгүй, нэмэгдэл цалин нь бол хэтрэхгүй энэ тэр гээд. Тэгэхээр энэ хуулийг Төрийн албаны зөвлөлөөс санаачилж ерөнхийдөө гаргаж өгдөг юм уу, эсвэл Засгийн газрын Хэрэг эрхлэх дээр санаачилдаг юм уу. Хэрвээ Төрийн албаны зөвлөл төрийн албан хаагчдынхаа эсрэг ийм хууль санаачилдаг бол ер нь тун хариуцлагагүй ажиллаж байна л гэж би хэлмээр байгаа юм. Тэгэхээр энэ хаанаас санаачилдаг хууль юм бол. Энд нэг хариулж өгөөч.

2 дугаарт ер нь энэ Төрийн хэмнэлтийн тухай хууль гээд хууль батлагдсаныг та нар мэдэж байгаа. 2024 онд. Ерөнхийдөө их алаг үзэлтэй хууль болсон боловч төрийн үйлчилгээний салбарт бол их хохирол авчирсан хууль. Дээд түвшиндээ задгай байдлыг даврааж өгөөд, Их Хурлын харьяа байгууллагууд, Засгийн газрын байгууллагууд орлогч дарга хэдтэй ч байж болдог, хэчнээн ч машин унаж болдог энэ эд нарыг нь тавиад өгчхөөд, төрийн үйлчилгээ дээр очсон чинь орлогч байж болохгүй, унаа унаж болохгүй. Тэгээд манай зарим хүрээлэнгүүд чинь олон улсын төсөлд ирсэн машинаа хүртэл хураалгасан тохиолдол байгаа. Энэ эргэж нэг их

сайжраагүй. Одоо тэгсэн чинь бас эрх мэдэлтэй хүмүүс би Жавхлан сайдаас асуух гэж байгаа юм. Энэ төрийн өмчит үйлдвэрийн газарт орлогчийн зиндааны орон тоо гаргаад 3, 4 хүн авчихсан. Менежер, янз бүрийн менежер гээд. Тэгээд энэ бол төрийн хэмнэлтийн тухай хуулийг бол агуулгаараа маш ноцтой зөрчсөн ийм хууль яваад байгаа юм. Тэгэхдээ зэрэг энэ шүүмжлэл хүлээж байгаа менежерийн асуудлыг Төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн гэж үзээд энэ төсвийн тодотголдоо ер нь та нар яаж авч үзсэн юм бэ. Энэ ер нь нийт төрийн өмчит үйлдвэрийн газруудтай хандах хандлага бусад төрийн үйлчилгээний байгууллагуудаас ийм ялгаатай байж болохгүй л гэж би бодож байгаа учраас ингэж асууж байгаа шүү.

Б.Баярбаатар: Сангийн сайд хариулах уу.

Б.Жавхлан: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны тухай хууль энэ удаа цэвэр яг төсөв талаасаа бид нар санаачилж оруулж ирсэн. Тийм Сангийн яамнаас. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ч оролцоогүй, оролцуулаагүй, Төрийн албаны зөвлөлөөс ч оролцуулаагүй шууд ингээд ер нь сүүлийн жилүүд дээр ийм судалгаанууд бол хийгдээд, санал солилцож байсан зүйлүүд бол байгаа. Яах вэ энийг тэгээд нэгэнт татахаар болчихсон учраас дахин дахин тайлбарлаад яах вэ. Бүлэг дээр нэлээн дэлгэрэнгүй ярилцсан. Ер нь санаа нь агуулга дээрээ бол бид нар ухрахгүй, хэвээрээ байгаа юм. Энэ удаа татаж байгаа л болохоос биш дараа ярилцаж байгаад хэзээ тохиромжтой болох нь вэ, арай өөр хэлбэрээр ч юм уу, арай бага багаар, алхам алхмаар ч юм уу энэ зүйлүүд рүүгээ бол явна.

Жишээ нь Рэгдэл гуай тэр доктортой холбоотой. Төрийн албан хаагч маань яг доктор цолоо хамгаалаад, тэр нь өөрийнх нь яг тухайн ажлын байрных нь бүтээмжид нь нөлөөлөөд, гүйцэтгэлийн санхүүжилтээ аваад, өндөр нэмэгдэл юмнуудаа аваад явж байвал тэр дээр нь бол тохируулж болж байна. Тэгэхгүй ингээд бас хавтгайрсан, яг цалингийнхаа нэмэгдэл авах хэрэгсэл болгоод доктор аваад, тэр доктор нь шууд ажлынх нь байр дээр нь шууд ажлын бүтээлд нь нөлөөгүй ийм зүйлүүд бас их хавтгайраад байгаа учраас тэр нь яг хэрэг болж байгаа тэр ажлын байрууд дээрээ л үйлчлэх нь зөв юм гэх мэт зүгээр иймэрхүү санаанууд орж ирсэн зүйлүүд байсан. Тэгээд би таны асуултад бол шууд хариулчихлаа. Тэр бол Сангийн яамнаас оруулж ирсэн. Тэрийгээ ч хамгаална. Тэгэхдээ энэ удаадаа улс төрийн шийдвэр гарсан учраас татсан. Тэрийгээ би мэднэ ээ.

Төрийн хэмнэлтийн хууль дээр одоо бид нар гар хүрээд дэмий байх. Энийг ер нь бүх чиглэлээр л хэмнэлтээ хийе гэж байгаа байгаа учраас энийгээ хийгээд л явах нь зөв байх. Харин энэ удаа төрийн хэмнэлтийн хуулийг бид нар ер нь буцаад зөөлрүүлэх, сулруулах гэсэн тийм чиглэл юмнууд ирээд байсан. Огт тийм бол хийгээгүй, тусгаагүй. Харин тодотголыг дагасан тогтоол орж ирж байгаа. Харин тэр дээр Их Хурлын гишүүд маань бас, би ч бас санал гаргая гэж бодож байна. Бас олон хүмүүс ярьж байгаа учраас энэ төрийн өмчийн үйлдвэрийн газруудын тэр олон дарга, цэргүүдийг бас хэмнэлтийн хуулийн дагуу энийг эргэж харах тогтоолд нь бас заалт оруулчихвал болох юм. Тэрнээс бол төсөвт бол энэ чинь шууд нөлөө байхгүй байхгүй юу. Төрийн өмчийн үйлдвэрийн газрууд чинь төсөв шууд тусдаа. Төрийн өмчийн үйлдвэрийн газруудын төсөвтэй холбогддог 1 л юм байгаа. Тэр нь ноогдол ашиг.

Б.Баярбаатар: Рэгдэл гишүүн тодруулъя.

Д.Рэгдэл: Бид 2 чинь уулзахад хэцүү юм чинь бас ганц 2 өгүүлбэр хэлнэ ээ Танд зориулаад. Энэ эрдмийн зэрэг цолны нэмэгдэл байна шүү дээ. Энэ бол социализмын үед эрдэмтэн боллоо гэж өгдөг нэмэгдэл байсан. Агуулга нь. Өнөөдөр энэ өндөр боловсрол эзэмшлээ гэж олгож байгаа мөнгө. Зэрэг цолны нэмэгдэл огт биш юм байгаа юм. Чи бакалавраар төгсөөд ажиллаж болно. Тэгвэл цалин чинь ийм байна. Магистраар төгсвөл ийм байна. Доктороор төгсвөл ийм байна гэж л энэ агуулгаараа ингэж ойлгох ёстой. Энэ бол нэмэгдэл биш юм байгаа юм шүү дээ. Тэгэхээр хаана ажиллаж байна вэ. Төрийн байгууллага, төрийн захиргаа, тусгай хаана ч ажиллаж байсан энэ өндөр боловсрол эзэмшиж байна гэж манай улсынхаа боловсролын тогтолцоог ойлгодог, хүндэлдэг хүн бүр тэгж бодоод энэ нэмэгдлээр ерөөсөө оролдмооргүй байгаа юм. Тэрүүнд нь өгнө, Баярбаатарт өгнө, Рэгдэлд өгөхгүй гэж болохгүй. Бид 2 доктор бол адил..../минут дуусав/

Б.Баярбаатар: Рэгдэл гишүүнд 1 минут нэмээд өгчих үү. Болчихсон уу та. 1 минут нэмэх үү. Болчихсон уу. 1 минут өгчих.

Д.Рэгдэл: Тэгэхдээ зэрэг эрдмийн зэрэг цолны гэдэг юмыг ер нь оролдоод хэрэггүй юм байгаа юм. Энэ бол хүн өндөр боловсрол эзэмших тэр сэдэл санаа өгч байдаг бас нэг цалингийн систем болохоос биш, эрдэмтэй боллоо гэж шагнаж байгаа шагнал бол биш байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт энэ орон тооны хэмнэлтийн асуудлаар зарим яаманд эрдэм шинжилгээний хүрээлэнд орон тоогоо 9 хувь цомхотго гэсэн бичиг өгч байгаа сураг байна. Энийг бол арай ингэхгүй байлгүй л гэж бодоод байгаа. Тийм юм бол төсвийн тодотгол дээр яригдсан уу. Яригдаагүй явчихсан юм уу.

Б.Баярбаатар: Сангийн сайд хариулах уу. Ер нь төрийн албаны цалин хөлсний систем бол цаашдаа яг гүйцэтгэлтэй нь, үр дүнтэй нь илүү их уялдах хэрэгтэй гэдэг ерөнхий ийм суурь зарчим руугаа л явж байгаа шүү 1 дүгээрт.

2 дугаарт саяын таны яригдсан зүйл болж байгаа. Одоо ч болж байгаа. Ингээд тодотгол батлагдмагц ер нь яг орон тоотой холбоотой тэр зардал дээр 9 хувийн хэмнэлт үүснэ. Тэрийгээ харин орон тоотойгоо холбох уу, бусад зардалтайгаа холбох уу гэдгийгээ сайд нар төсвийн ерөнхийлөн захирагч нар үлдсэн хугацаанд шийдээд явна гэсэн үг.

Б.Баярбаатар: Өнөөдрийн хурал төсвийн гүйцэтгэл, төсвийн тодотгол гээд 2 зүйлийг хэлэлцэж байна. Төрийн албаны зөвлөлийн удирдлагууд ер нь энэ төсөв хэлэлцэх болохоор ингээд зугтчихдагаа ер нь хэзээ болих вэ. Тэгээд хариулт, асуултад нь өнөөдөр Сангийн сайд хариулаад сууж байдаг. Танай дээр Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга гээд 1 хүн байдаг биз дээ. 5 орон тооны гишүүний чинь ядаж 1 нь ирж болдоггүй юм уу. Тэр байгууллагын чинь төсөвтэй холбоотой зүйлийг яриад байна шүү дээ. Эсвэл дургүй байгаа бол дургүйгээ илэрхийлэх хэрэгтэй шүү дээ. Төрийн алба хашиж байж.

Энэ ер нь төсөв хэлэлцэх цаг үеэр нэг баахан төрийн байгууллагын удирдлагууд Улсын Их Хурлын гишүүд рүү ханддагаа болих хэрэгтэй. Манай төсвийг тэдээр ч нэмээд өгөөч, ийм ч юм суулгах гэсэн юм ,энийг ч дэмжээд өгөөч. Тэгээд дэмжээд суулгаад өгдөг одоо энэ гүйцэтгэлээ хар л даа та нар. Буцаагаад баахан мөнгө татуулж байдаг. Тэрийг дэмий суулгаж байхаар хэрэгтэй газар нь

байх ёстой шүү дээ. Бараг энэ хүснэгтээс чинь харахад Сангийн сайд өшөө ч дахиад танамаар зүйлүүд харагдаад байна шүү дээ энэ дээр. Одоо жишээлбэл энэ Хэрлэн гишүүний яриад байгаа зөв шүү дээ. Энэ бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж гээд нийтдээ 6,1 тэрбум төгрөг байгаа байхгүй юу. Энэ дотор нь задалбал энд юу байгаа юм бэ л гэдэг асуудал шүү дээ. Тэгээд эндээс 2,7 тэрбумыг нь төсвийн тодотголоор танаж байгаа юм байна. 3,3 үлдэж байгаа юм. Тэгээд энэ ажил гэж ер нь яг юу юм. Энийг дотор нь задалбал бас юм байгаа шүү дээ. Тэгээд ер нь цаашдаа энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил гэдэг зүйлээ ер нь жоохон задалж оруулж ирж байх нь зөв шүү.

Хэдхэн сарын дараа наадам өнгөрөөд 8 сар дуусаад бид нар төсвөө хэлэлцэж эхэлнэ. 2026 оны төсөв. Энэ дээр Сангийн яам би та бүхэнд микрофонд үг хэлж байгааг ашиглаад хэлчихье. Маш чамбай төсөв оруулж ирээрэй. Оруулж ирсэн төсөвтөө эзэн байгаарай. Ашиг сонирхол лоббид битгий өртөөрэй. Энэ төсвийн мөнгө гэдэг чинь татвар төлөгчдийн мөнгө. Энэ 1 төгрөгийг ч гэсэн бид нар өнөөдөр зөв зүйтэй зүйлд нь зарцуулах ёстой болохоос биш 1 байгууллагын дансанд тоо бичигдээд, бүтэн жил хадгалаад, буцаагаад татдаг асуудал биш шүү. Аудит ч гэсэн энэ дээр хариуцлагатай хяналт тавиарай. Энэ аудитын байгууллагын баахан зөрчилтэй тоонууд гараад байдаг. Хариуцлага тооцож байгаа зүйл байдаггүй. Дахин дахин зөрчил байна л гээд мэдээлээд байдаг. Тэгээд яг өнөөдөр хэн ямар хариуцлага хүлээж байна.

Өнөөдөр ингээд Ёс зүй, дэгийн байнгын хороо цаг хугацаандаа шахагдаад төсвийн тодотголоо энэ 7 хоногтоо батлах ёстой, дээр нь улсын баяр наадам болох гэж байна. Нэгдсэн чуулган завсарлах гэж байна гэсэн ийм 3 үндсэн зүйлд шахагдаад өнөөдөр хэлэлцсэн болоод л өнгөрлөө шүү дээ. Яг ний нуугүй хэлэхэд. Би яг ний нуугүй хэлэхэд хойшлуулчихмаар л байна. Эхний 1, 2 дахь асуудлыг би бол хойшлуулчихмаар л байсан шүү. Төрийн албаны зөвлөлөөс ирж сууж байгаа хүмүүс анхаараарай та нар.

Дээр нь энэ Байнгын хороо, нэгдсэн чуулганы танхимд байгууллагаа төлөөлж ирж байгаа юм бол асуултад хариулчих хэмжээний албан тушаалтныг явуулж бай. Энэ парламентын асуудалд хүндэтгэлтэй ханд эрхэм албан хаагчид аа. Аль болох л боломжоор нь хангаад л, дэмжээд л, асуудлыг нь ойлгоод л хуулийг нь батлаад л хамгаалах зүйл дээр хамгаалаад л явж байгаа шүү дээ. Ажлын албаны дарга та аль Байнгын хорооноос орж ирэв. Ямар хурал. Тэгээд яадаг юм. Бүгдээрээ орчихдог юм уу тэр лүүгээ. Энд төрийн ажил явагдаж байна шүү дээ. Тэр ажил чинь төрийнх болоод, бид нар төрийнх биш юм уу эсвэл. Энд төсөв чинь яригдаж байна хөөе. Дараа дараадаа ийм алдаа дутагдал гаргахгүй шүү нөхдүүд ээ. Хариуцлагатай хэллээ шүү.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу. Байхгүй байна.

Төсвийн тодотгол төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Ёс зүй, дэгийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна. 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Баярлалаа.

3 дахь асуудалдаа орно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа нарын 20 гишүүн 2025 оны 6 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэнэ. Анхны хэлэлцүүлэг явуулна.

Хэлэлцүүлгийн гарсан дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна. Булгантуяа даргын микрофоныг өгье.

Х.Булгантуяа: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 192 дугаар захирамжаар Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсөв, төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах, бусад хууль тогтоомжийн төсөвт үзүүлэх нөлөөллийг судлан санал, дүгнэлт боловсруулж, Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяагаар ахлуулан 26 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Ажлын хэсэг 2024 оны Улсын Их Хурлын 52, 54 дүгээр тогтоолын хэрэгжилт, гадаад зээл, тэтгэмж, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон нийгмийн салбарын төсөв, эдийн засаг, дэд бүтцийн салбарын төсөв, төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа, орон тоотой холбоотой мэдээлэлтэй танилцаж, санал, дүгнэлт гаргаснаа Төсвийн байнгын хороонд танилцуулсан байж байгаа.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсөв, төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах, хууль, эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд дараах өөрчлөлтүүдийг хийж, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулаад өргөн бариад байн.

Нийтдээ манай Улсын Их Хурлын 20 гишүүн хамтран өргөн барьсан. Төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 1-ний өдөр өргөн барьж байгаа. 11 дүгээр сарын 15-нд батлахаар байгаа. Харин Улсын Их Хурлын намрын чуулган 10 дугаар сард эхэлж, эхэлсэн даруйдаа төсвийн төслийг хэлэлцэж эхэлж байгаа. Бид иймд Улсын Их Хурлын намрын чуулганы 9 дүгээр сарын 15-ны өдрөөс эхэлж төсвийн төслийг намрын чуулган эхэлсэн өдрөөс эхлэн хэлэлцүүлэхээр төсвийн төсөлтэй танилцах хэлэлцүүлгийн шинэ үе шат нэмж, нийтдээ 5 үе шаттайгаар хэлэлцдэг байх нэмэлт, өөрчлөлт холбогдох хуульд оруулахаар тусгалаа.

Мөн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд зөвхөн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний танилцуулгыг сонсож, ердийн хуулийн төсөл хэлэлцэх журмын дагуу Улсын Их Хурал хэлэлцэн баталж байгаа. Тэгээд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь бол дараа жилийн макро эдийн засаг төсвийн үндсэн үзүүлэлт болох чухал баримт бичиг юм. Тийм учраас 4 үе

шаттайгаар Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх тусгайлсан дэгийг бий болгож, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар сонсож, бүх Байнгын хороодоор хэлэлцэж, санал, дүгнэлтээ төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ. Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хуралдаж хамтарсан санал, дүгнэлт гаргах зохицуулалтыг бий болгож, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлтийг тусгалаа.

Мөн Улсын Их Хурал төсвийн хүрээний мэдэгдлийг батлахдаа нэгдсэн төсвийн зарлагын дээд хэмжээгээр баталдаг. Мөн Засгийн газар Улсын Их Хуралд нэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайлангийн хамт өргөн мэдүүлээд улсын төсвийн гүйцэтгэл батлах тухай тогтоол баталдаг. Энэ нь Улсын Их Хурал төсвийн гүйцэтгэлийг бүхэлд нь хянаж батлахгүй байгаа буюу өөрөөр хэлбэл орон нутаг, нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын сан, Үндэсний баялгийн сангийн төсвийн гүйцэтгэлийг хянан батлахгүй байгаа явдал юм. Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд зохих өөрчлөлтийг тусгалаа.

Засгийн газраас дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл, хөгжлийн төлөвлөгөөний төсөл, хөгжлийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад баримт бичиг тодорхой хугацаанд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд хүргүүлэх, Улсын Их Хуралд танилцуулах эрх зүйн зохицуулалт бий болгох шаардлагатай байна. Ингэснээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд хуульд заасан дүгнэлт гаргаж, хяналт тавих, Улсын Их Хуралд танилцуулах чиг үүргийнхээ хүрээнд ажиллах зохицуулалтыг бид бас нэмж тусгаж өглөө.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсөвт тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээн авсантай холбоотойгоор төсөв хэлэлцэн батлах хугацаа чуулганы хуралдааны дэгийн зохицуулалтыг нэмж тусгалаа. Ерөнхийлөгчөөс бүхэлд нь хориг тавих юм бол Засгийн газарт буцаадаг байх. Хэсэгчлэн хориг тавих юм бол Мэргэжлийн байнгын хороо, Төсвийн байнгын хорооны саналаар Улсын Их Хурал Засгийн газарт нь буцаах, эсвэл Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гарч ажиллах ийм зохицуулалттайгаар бас тусгасан.

Ингээд ийнхүү Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль Улсын Их Хурлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль зэрэг холбогдох хуулиудад өөрчлөлт оруулахаар хамтад нь өргөн барьсан байж байгаа.

Мөн Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулахаар өргөн барьсан.

Б.Баярбаатар: Булгантуяа даргад баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.3-д “Нэг хуулийн төслийг хэд хэдэн байнгын хороо хэлэлцээд санал, дүгнэлт гаргахаар хууль тогтоомжид заасан бол тэдгээр нь хуралдаанаа тус тусдаа зохион байгуулж, санал, дүгнэлтээ зарчмын зөрөөтэй саналын томьёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.” гэж заасан байгаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал ирээгүй. Өнөөдөр 13 цагаас өмнө зарчмын зөрүүтэй санал ирэх ёстой байсан.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д “Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.” гэж заасны дагуу зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг уншиж танилцуулна.

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд доор дурдсан агуулга бүхий дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/64 дүгээр зүйлийн 64.4 дэх хэсэг:

“64.4.Төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцүүлэхтэй холбоотой энэ зүйлд заасан журмаар зохицуулаагүй бусад асуудалд энэ хуульд заасан хуулийн төсөл хэлэлцэх журмыг баримтална.”

2/69¹ дүгээр зүйл:

“69¹ дүгээр зүйл.Төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг

69¹.1.Ерөнхий сайд төсвийн төслийн танилцуулгыг, Монгол Улсын Ерөнхий аудитор төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга төсвийн төсөл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан эсэх талаар дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд тус тус танилцуулна.

69¹.2.Төсвийн төсөлтэй холбогдуулан төрийн аудитын төв байгууллага болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хийсэн дүгнэлтийг гишүүдэд хүргүүлнэ.

69¹.3.Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт төсвийн төслийн талаарх илтгэлийг Ерөнхий сайд танилцуулна. Ерөнхий сайдын илтгэлд төсвийн төслийг боловсруулахад олон нийтийн оролцоог хангаж ажилласан байдал, гарсан үр дүнг төсвийн төсөлд тусгасан талаар танилцуулна.

69¹.4.Нэг дэх хэлэлцүүлэгт Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга болон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Шүүхийн сахилгын хорооны дарга, Улсын ерөнхий прокурор, Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга нар оролцоно.

69¹.5.Гишүүд энэ хуулийн 69¹.1-д заасан илтгэлтэй холбогдуулан Ерөнхий сайдаас, энэ хуулийн 69¹.2-т заасан дүгнэлттэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн даргаас, төсвийн төсөлтэй холбогдуулан энэ хуулийн 69¹.3-т заасан төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлнэ.”

3/73¹ дүгээр зүйл:

**“73¹ дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авч
төсвийг хүчингүй болгосонтой холбогдуулан
төсвийн төсөл хэлэлцэх**

“73¹.1.Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль, тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг Улсын Их Хурал хүлээн авч, хууль, тогтоол хүчингүй болсонд тооцсон бол Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаас тогтоосон хугацаанд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгана. Монгол Улсын Ерөнхийлөгч тухайн жилийн төсөвт хэсэгчилсэн байдлаар хориг тавьсан тохиолдолд хоригийн шинж байдлыг харгалзан Улсын Их Хурал Засгийн газарт тогтоосон хугацаанд төсөл өргөн мэдүүлэхийг даалгаж болно.

73¹.2.Төсвийн тухай хуулийн 32¹.1-д заасны дагуу Засгийн газар холбогдох төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Улсын Их Хурал энэ хуулийн 71, 72, 73 дугаар зүйлийн дагуу хэлэлцэж, Төсвийн тухай хуулийн 32¹.5-д заасан хугацаанд батална.

73¹.3.Энэ хуулийн 73¹.2-т заасан төсвийн төслийг хэлэлцэхэд энэ хуулийн 39.14, 39.30-д заасан хугацаа, 71.4 дэх хэсэг хамаарахгүй.

73¹.4.Энэ хуулийн 73¹.2-т заасан төсвийн төслийг хэлэлцэх цаглавар, хугацаатай уялдуулан Төрийн аудитын байгууллага болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг гаргуулж болно.”

1 дүгээр зүйлийг уншиж танилцууллаа. 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу. Үг хэлэх үү. Асуулт, үг хамт. Жавхлан гишүүнээр тасаллаа. Жавхлан гишүүн.

Б.Жавхлан: 5 жил анх удаа асуулт асууж үзэх эгж байна. 5 жил байцаагдсаар байгаад. Булгантуяа гишүүнээс асууя. Энэ ингээд зарчмын хувьд маш том өөрчлөлт орж байгаа шүү дээ. Энэ чинь бүр тогтолцооны хувьд бол 34 жил явж ирсэн цаг хугацааны энэ цаглаварт маш том өөрчлөлт орж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийгээ их сайн олон талаас нь харах ёстой байх гэж бодож байна. Ганцхан энэ удаагийн Засгийн газар биш, ганцхан удаагийн Их Хурал биш. Энэ чинь цаашаагаа магадгүй дахиад 30 жил ч явах ийм цаглаврыг бид нар өнөөдөр өөрчилж байгаа байх. Тэгэхээр ийм юм байна. Ингээд яг амьдрал дээр харахаар Монголчууд маань ер нь 2 л календарийн хугацаатай юм байна. Цагаан сарын өмнө, хойно, наадмын өмнө, хойно гэдэг л ийм хугацаатай. Тэр төсвийг 10 сарын 1-нд өргөн барьдаг хугацаа бол мэдээж Улсын Их Хурал эхлэх гэж байгаатай холбоотой. Тэгээд хүүхдийн амралт эд нар гээд хойшоогоо хоног өдрийг нь тоолохоор чинь бас яг тааруулаад л хийчихсэн байдаг байсан юм байна лээ. Тэгээд Үндсэн хуулиар сүүлд намрын чуулган, хаврын чуулганы өдрүүдийг бас жоохон өөрчилчихсэн. Одоо ингээд дүүрч ноднин өөрчлөөд 9 сарын 1-ээс өргөн барьдаг болчихсон. Тэгээд ноднин амьдрал дээр бас ингээд харлаа. Цаашдаа ч үе үеийн Засгийн газар, дараа дараагийн Засгийн газар, Сангийн сайд нар зөндөө л энэ зовлонг нь амсах байх. 9 сарын 1-нд төсөв өргөн барина гэдэг бол Засгийн газрын өөрийнх нь үндсэн үүрэг төсвийг төлөвлөх үүрэгтэй. Их Хурал батлах үүрэгтэй. Дараа нь Засгийн газар энийг гүйцэтгэлээр хангах үүрэгтэй. Төлөвлөх шатанд нь аягүй эрсдэл гарч ирж байгаа юм. Төлөвлөх шатанд. Засгийн газрын энэ төлөвлөх шатанд бол бүх төсвийн ерөнхийлөн захирагчид, бүх төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч нар оролцож явж байх ёстой. Оролцоог жигд

хангаад явж байх ёстой. Гэтэл 9 сарын 1-нд гэгчхэнгүүт үндсэндээ ганцхан Сангийн яамны л төсөв болчихоод байгаа юм. Энэ хийсэн төсөв нь. Хийж байгаа төсөв маань. Монголын ард түмэн наадмаас хойш бүгд амарчихдаг. Бусад төрийн албан хаагч нар, төрийн байгууллагууд, яамнууд үндсэндээ амарчихдаг. Тэнд нь сайд нь орж гараад, санхүүгийнхэн нь орж гараад. Тийм учраас яг төлөвлөлтийн шатад нь ийм алдаа гарах, дутуу судалгаа үндэслэл муутай ийм эрсдэлүүд нэлээн гарна. Би энийг муугаар зөгнөж, муу үг хэрэглэмээргүй байна. Гэхдээ та бүхэн анхаараарай. Энэ дээр алдаа гарна. Амьдрал дээр алдаа гарч таарна. Энэ жил ингээд давтагдаад явна. Уг нь бол бид нар шинэ төсөв өргөн барихдаа хугацааг ядаж 10 сарын 1 биш юм гэхэд 9 сарын 15 болгож өгөөч ээ гэж ийм өөрчлөлт оруулъя гэж байсан юм. Гэтэл энэ цаглаврыг Засгийн газраас санал аваагүй л дээ. Тэгээд нөгөө төсвийн төлөвлөлтийн хугацаа руу бас энэ чинь оролцож, нөлөөтэй байгаа учраас уг нь бид нараас санал авсан бол зүгээр байсан юм. Ингээд шууд яваад орчихоор бид нар 9 сарын 15 гээд .../минут дуусав/

Б.Баярбаатар: Гүйцээгээд асуучих.

Б.Жавхлан: 15 болгож өгөх хугацааны боломжгүй тийм хайч руу орчхож байгаа юм л даа энэ юмаар. Тэгээд нөгөө 4 хэлэлцүүлэг маань 5 хэлэлцүүлэгтэй болчихлоо. Тэр ч дүүрч. Одоо тэгээд Их Хурлын гишүүд маань илүү их л ажилтай болохтой дуртай байгаа байх л даа. Ийм байна. Тэгээд миний асуулт ийм байна. Энийг буцаагаад хуучнаар нь тавихаар ямар эрсдэл байна. 1 дүгээрт.

2 дугаарт одоо оруулж ирж байгаа энэ төсөл дээр 9 сарын 15-нд эхний хэлэлцүүлэг болох гэж байгаа. Танилцуулах гэж байгаа. Танилцуулга нөгөөдөх нь нөгөө хангаж байгаа юу эсэхийг цаашаа хэлэлцэх үү, үгүй юу гэдгийг шийдэх гэж байгаа. Тэгэхээр 9 сарын 15-нд хийх хэлэлцүүлэг ямар бүрэлдэхүүнтэй хийх вэ. Чуулганаа 9 сарын 15 болтол татчихаж байгаа юм уу. Чуулган 9 сарын 15-нд эхлэх гэж байгаа билүү. Нөгөө 10 сарын 1 маань 126-уулаа 9 сарын 15-нд эхэлье гээд. Тэгэхээр чуулган нэгдсэн бүрэлдэхүүнээрээ чуулганаа хийгээд хэлэлцүүлгээ хийх юм уу. хариултаа авъя.

Б.Баярбаатар: Төсөл санаачлагч Булгантуяа гишүүн хариулъя.

Х.Булгантуяа: Бодит үнэнийг хэлэхэд би бол бас өөрөө Сангийн яаманд ажиллаж байсан хүний хувьд анх бол 9 сарын 1 болоход бол та өөрөө мэдэж байгаа. Энэ ч хэцүү дээ, халуун зунаар хамаг амьтад төсөв боох л төрийн албан хаагчид ийм ажилтай болно доо гээд бол үнэнийг хэлэхэд бол дуртай, дургүй байсан. Тэгээд энэ хууль бол батлагдаад хэрэгжээд 9 сарын 1-нд өнгөрсөн намар бол өргөн баригдсан. Харамсалтай нь 9 сарын 1-нд өргөн баригдсаны хэрэг ерөөсөө гараагүй. Яагаад гэвэл намрын чуулган 10 сар гартал хуралдахгүй учраас ингээд D-Parliament дээр тавьсан юм шиг байгаа юм. Тэгээд 9 сарын 20 хэдэн хүртэл Үндэсний аудитын газар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтүүд нь гарахгүй. Ингээд бид нар эрт Засгийн газраас өргөн барьсны хэрэг ерөөсөө гараагүй. Тэгэхээр үнэнийг хэлэхэд буцаад 9 сарын 15, 10 сард өргөн баригддаг болно гэхээр зүгээр 1 зүйл анзаарагдаж байгаа нь Жавхлан сайд аа, одоо ингээд одоогийн хуулийн дагуу дэгээр Улсын Их Хурлын гишүүд сая бол төсөвтэй холбоотой жоохон бухимдсан зүйл нь 2 хоног танилцуулга хийгээд, эхний өдөр Ерөнхий сайд төсвийнхөө танилцуулгыг уншаад, ингээд төсвийн ерөнхийлөн захирагч нараас 2 хоног бид нар асуулт асуусан. Санаж байгаа бол. Бид нар 2 хоног нэгдсэн чуулган дээр асуулт асуугаад, тэгээд ерөөсөө нарийн сайн танилцаж

олигтой асуулт ер нь бол ийм 32 их наядтай холбоотой асуудлыг бид нар 3 минутад асуух болчхож байгаа байхгүй юу. Тэгээд араас нь 1, 1 удаа тодруулга авбал аваад, 5 минут нь асуулт асуугаад, хариулт аваад, тэгээд түүнийхээ итгэл үнэмшлээр энэ төсвийн төсөл бол хуульд нийцэж байна, хэлэлцэх эсэхийг нэг бодлын дэмжье гэдэг санал хураалт хийгээд явъя гэж хэтэрхий их шахаж байна гэсэн ийм шүүмжлэл бас байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар бол яаж байна вэ гэхээр нэгэнт одоогийн хуулиар бол 9 сарын 1-нд өргөн барьж байгаа.

Тэгэхээр нэгэнт 9 сарын 1-нд өргөн барьчихаж байгаа юм бол 9 сарын 15-аас 1 дүгээр хэлэлцүүлгээр Ерөнхий сайд танилцуулгаа уншаад, Аудитын газрын дарга дүгнэлтээ уншаад, Төсвийн тогтвортой байдлын дарга дүгнэлтээ уншаад, араас нь төсвийн ерөнхийлөн бүх захирагч нараас Улсын Их Хурлын гишүүд асуулт асуугаад мэдээлэлтэй болчхоод бид нар тойрог дээр очиж ажиллая. Тэрний дараагаар хэд хоног завсарлана гэсэн үг. Бараг 2 7 хоног хэртэй. Ингээд энэ хугацаанд бол бид нар яг үнэнийг хэлэхэд тойрог дээр очоод ажиллахад иргэдээс ирэх жил цалин яах юм, тэтгэвэр яах юм, манай орон нутгийн хөрөнгө оруулалт яах юм гэдэг асуултуудад бид нар илүү их мэдээлэлтэй 2 хоног ер нь бол төсвийн хэлэлцүүлгийг сонсоход маш сайн мэдээлэлтэй болчхоод байна шүү дээ. Тэгэхээр мэдээлэлтэй очиж хэлэлцүүлгүүдээ хийх үүд хаалга нээгдэнэ. Нийгмийн сегментийн төлөөлөл болж өнөөдөр жагсаалтаар орж ирсэн гишүүд маань ч гэсэндээ эрүүл мэндийн салбарынхаа, боловсролын салбарынхаа, шинжлэх ухааныхаа салбарын хэлэлцүүлгүүдийг хийж ороод, 2 дахь хэлэлцүүлгүүд дээр энэ хэлэлцүүлгийг явуулсан чинь орон нутаг дээр, тойрог дээрээ, нийгмийн сегментийн хэлэлцүүлгийг явуулсан чинь ийм асуултууд гарч байна, ийм саналууд гарч байна гээд холбогдох Байнгын хороодоор ирээд асуулт асуугаад, төсвийн захирагч нараасаа асуулт асуугаад тодруулгууд авна. Түүний дараагаар Төсвийн байнгын хорооны дарга бусад одоо ингээд 8 Байнгын хороотой болох гэж байгаа бол 7 Байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтээ нэгтгээд, нэгдсэн чуулган дээр танилцуулаад, гишүүд Байнгын хороо дээрээ асуулт асуулаа. Тойрог дээрээ хийсэн уулзалтуудынхаа араас санал хэллээ. Ийм ийм саналууд гарлаа, ийм ийм асуултууд асуулаа.

Одоо та бүхэн энэ хүрээнд тэгвэл төсвөө хуульд нийцэж байна уу, хэлэлцэхийг дэмжих үү гэдэг ийм санал хураалтыг явуулах юм бол гишүүд маань улам их мэдээлэлтэй, илүү их итгэл үнэмшилтэйгээр тэр төсвийн хэлэлцүүлэг бол явах боломжтой юм байна. Ер нь бол би анх удаа төсөв дээр ингэж олон нийтийн анхаарал өнгөрсөн намар маш их өндөр байгааг бол харлаа. Тэгэхдээ энийг бол би бас зөв гэж бодож байна. Улсын Их Хурлын гишүүдийг бид нар мэдээллээр хангахад Засгийн газар цааргалахгүй байх ёстой. Олон нийтийн хэлэлцүүлэг явуулах нь бол зүйтэй. Энэ бол татвар төлөгчдийн мөнгө болохоос биш Засгийн газрын, бидний өөрсдийн ч мөнгө бас биш. Тэгэхээр үүнийхээ араас олон нийтийн оролцоог хангах энэ ажлаа хийхгүй бол бид нар үнэнийг хэлэхэд Улсын Их Хуралд эрт өргөн барьсны хэрэг бас гарахгүй болчхоод байна. Одоо бол 9 сарын 1-ийг буцаахад хэцүү юм байна лээ Жавхаа сайд аа. Үнэнийг хэлэхэд манай Төсвийн байнгын хороон дээр ч байгаа олон гишүүд өөрсдөө үүнийг өргөн барьчихсан. Танай Засгийн газрын гишүүд ч байгаа шүү дээ.

Б.Баярбаатар: Тодруулах уу. Жавхлан гишүүн тодруулъя.

Б.Жавхлан: Уг нь Булгантуяа сайд л хамгийн сайн ойлгох ёстой юм байгаа юм даа энийг амьдрал дээр яг яах вэ гэдгийг. 1 зүйл нь бол яг гарцаагүй үнэн.

Ноднин жишээ нь 9 сарын 1-нд чуулган байхгүй үед шал дэмий 1 сарын хугацаагаар Засгийн газрыг торгоод, ингээд өргүүлчхэж байгаа байхгүй юу. Уг нь дахиад төлөвлөлтүүдээ хийгээд, тэр дээрээ маш сайн судалгаа шинжилгээтэй ажиллаад, нөгөө шинэ сайд нар чинь энэ дээрээ ажиллаад, тэгээд шинэ сайд нар чинь ерөөсөө төсвөө ч харж үзээгүй, харж барьж үзээгүй л өргөн барьчихсан шүү дээ. Хугацаандаа баригдаад. Тэгээд Их Хурал дээр хэлэлцэж байхад л миний төсөв ийм юм уу, чиний төсөв ийм юм уу гэж байгаа байхгүй юу. Зүгээр эхний жилд болд жишээ нь. Энэ жил бас харьцангуй шинэ сайд ирээд, бид нар шахаад л байгаа. Та нар ийм ийм учиртай шүү гээд. Тэгээд уг нь тэр сарын хугацааг төлөвлөх шат руу нь хугацааг нь тийш нь өгчихвөл зүгээр байсан юм. Яг тэр 1 сарын торгуулийг. Тэгэхгүй та 1 сарынхаа торгуулийг Их Хурал дээрээ авчихлаа шүү дээ. Их Хурал дээрээ аваад 1 сарын торгуулийг Их Хуралд .../минут дуусав/

Б.Баярбаатар: Хариулах уу. Булгантуяа дарга. Санал хэлсэн үү. 1 минут өгчихье. Жавхлан гишүүнд 1 минут.

Б.Жавхлан: Тэгэхээр миний санаа бол Их Хурал дээрээ тэгж авах биш, энийг төлөвлөлтийнхөө шатанд нь Засгийн газар луугаа өгчхөөч. Ядаж хагаслаад 15 хоногоор нь. Тэгвэл бид нар 9 сарын 15-нд өргөн барья гэдэг хугацаандаа өргөн барьчихна. 1 дүгээр санал ийм байна.

2 дугаарт хардаа. 9 сарын 15-нд аудитын дүгнэлт, төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцчихээд, ингээд гэрийн даалгавраа аваад гишүүд тойрог тойрог руугаа явчхаад, 10 сарын 1-нд ирээд дахиад 2 дахь хэлэлцүүлгээ хийнэ гэвэл төсөв зад үсэрнэ. Зад үсэрнэ. 7 сарын 25-нд яамнуудаас ямар төсвийн хязгаар ирдэг билээ гэдгийг Булгантуяа сайд маш сайн мэднэ. Төсвийн хязгаараас хэд дахин давчихсан, одоо 33 их наядын төсөв батлах гэж байхад 100 их наядын санал ирдэг. Ард түмэн тэрийг хэлэлцүүлчхээд ирэхэд 100 биш, 200 их наядын санал өвөртөлж ирнэ шүү. Тэгээд салбар салбарын улаан хамгаалагч нар болж ирнэ. Халамжаа нэмье гэж ирнэ. Тийм цэцэрлэг, сургууль .../минут дуусав/

Б.Баярбаатар: Булгантуяа дарга хариулъя.

Х.Булгантуяа: Сая бол Төсвийн байнгын хороон дээр энийг бас ярьсан. Тэгэхэд бол Төсвийн байнгын хороо дээр та мэдэж байгаа. Сая 9 сарын 1 болгох гэж өргөн барьсан маш олон гишүүд байгаа. Тэр хэд бол 9 сарын 1-ийг бол ер нь хөдөлгөхгүй шинжтэй юм билээ. Бид нар эрт танилцах ёстой гэсэн ийм байр суурьтай. Тэгээд нөгөө талдаа үнэнийг хэлэхэд төлөвлөлт бол зөв хийгдэх ёстой. 6 сар гээд төсвийн хүрээгээ баталчхаж байгаа. Засгийн газрын зүгээс 1 бодлын уг нь бол үйл ажиллагааны хөтөлбөрийг түрүүлээд батлуулчхаж байгаа юм. Тэгэхээр төсөв гэдэг чинь бол уг нь үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг батлуулсан хөтөлбөр дээр л мөнгө тавих чинь 1 бодлын төсөв шүү дээ. Уг нь бол тийм биз дээ. Тэрийг л санхүүжүүлэх гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар 3 сар хавьцаа бараг үйл ажиллагааны хөтөлбөрийг чинь жилийн төлөвлөгөөг чинь бараг батлаад өгчхөж байгаа юм. Тэгээд араас нь төсвийн хүрээг чинь батлаад өгчхөж байгаа юм. Тэгэхээр уг нь бол энэ бол нэг их тийм зовлонгүйгээр хийвэл .../минут дуусав/

Б.Баярбаатар: Гүйцээгээд хариулчихъя. Булгантуяа дарга.

Х.Булгантуяа: Дээрээс нь нэмээд бид нар бас ингэж байгаа юм. Яах вэ сонгуультай жил бол хэцүү гэдгийг ойлгож байгаа. Сонгуультай жилтэй холбоотой зарим улс оронд бүр тусгай дэг байдаг юм байна. Үүнийг бид нар төсвийн судалгааны хүрээлэнгээр бас судлуулж байна. Яг таны хэлж байгаа бол үнэн. Яг сонгуулийн дараах эхний төсвийг бол ер нь Сангийн яам л хийгээд өгчихдөг юм. Шинээр болсон сайд нар бол тэрүүнтэй танилцаж ч амжихгүй ороод, нөгөөдхийгөө хамгаалах үүрэгтэй болоод ийм хүнд байдалд ордог учраас түүнийг бол бас ойлгож байгаа. Магадгүй зүгээр сонгуультай жилд бол 10 сарын 1 байгаад бид нар 8 сард харин Улсын Их Хурлын чуулган хуралдаад, Засгийн газрын шинэ үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн төлөвлөгөө, төсвийн хүрээг шинэчилж баталж таарна. Ингээд аягүй бол төсвийн гүйцэтгэлийг гээд тэр бол 3, 4 7 хоног бараг хуралдаж таарах юм билээ. Харин бусад үед бол одоо 9 сарын 1-ийг хөдөлгөх бол хэцүү байх Жавхаа сайд аа.

Би бол Төсвийн байнгын хороо дээр бас сая энийг хэлэлцүүлсэн юм. Энэ хуулийг. Тэгэхэд бол 9 сарын 1-ийг бол эрс эсэргүүцэж байна лээ. Харин 10 сарын 1-ээс больё гэдэг дээр зарим нь бол 9 сардаа өргөн барьчаад .../минут дуусав/

Б.Баярбаатар: Жавхлан сайд 1 минут өгье.

Б.Жавхлан: Миний саналууд протоколд тэмдэглэгдээсэй гэж хүсэж байна. 3 сард төлөвлөгөө батална. Өргөн барина. Энийг манай гишүүд сайн анхаарч байгаарай. 3, 4 сард төлөвлөгөөний асуудал яригдана. 6 сарын 1-нд төсвийн хүрээ батлагдана. Эдийн засгийн байнгын хорооноос. Өөрөөр хэлбэл макро төлөвлөлт гэсэн үг. Энэ макро төлөвлөлтийн хүрээнд Засгийн газар 6 сарын 20 гэхэд Сангийн яам хүрээндээ багтаагаад танай яам энэ тоо, танай яамны тоо энэ тоо гээд хязгааруудаа сайд нартаа хүргэж өгдөг юм. Үүний дагуу 7 сарын 9-нд 7 хоногийн дараа, 14 хоногийн дараа сайд нарын анхан шатын төсвийн шууд захирагч нар буюу сургууль, цэцэрлэгийн багш нар ирэх жилийн миний төсөв ийм байна гээд сайд сайд нартаа явуулна. Тэрийг нь амралтын 10 өдрийг хэн нэг нь ажиллаж л таарна. Ингээд тэрийгээ нэгтгээд 7 сарын 25 гэхэд хуучин бол 8 сарын 15 байсан юм. 9 сарын 1 болсноос хойш 7 сарын 25 гэхэд .../минут дуусав/

Б.Баярбаатар: Одоо ингээд дараа дараадаа энэ чинь зүйл болгоноор хэлэлцэж байна шүү дээ. Одоо зөвхөн 1 дүгээр зүйлтэй, ер нь танилцуулж байгаа яг зүйлтэй нь холбоотой асуулт саналуудаа хэлэх нь зөв байх шүү. 1 дүгээр зүйлийг хэлэлцэж, асуулт асууж, үг хэлж дууслаа.

Ер нь бол яах вэ 2, 3 сарын хугацаанд энэ асуудлыг хэлэлцэж нэлээдгүй хүрээг хамарч хэлэлцсэн гэж би бол ойлгож байгаа.

2-т гэх юм бол энэ чинь өнгөрсөн жил бид нар 9 сарын 15 хавьцаа Тэрэлжид очиж төсөвтэй танилцаад, баахан хэл ам дагуулсныг л албан ёсны л болгож байгаа юм байна уу даа л гэж ойлгож байгаа шүү дээ.

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.2 дахь хэсгийн “10 минутад” гэсний дараа “, Төрийн аудитын төв байгууллага, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг тус бүр 5 минутад” гэж, 71 дүгээр зүйлийн 71.14 дэх хэсгийн “буцааж болно.” гэсний дараа “Чиглэл өгсөн тодорхой асуудлаас бусад асуудлыг хөндөхийг хориглоно.” гэж, 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн “хүчин чадал,” гэсний дараа “хэрэгжих

хугацаа,” гэж, 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсгийн “69,” гэсний дараа “69¹,” гэж, 74 дүгээр зүйлийн 74.4.2 дахь заалтын “Байнгын хороод” гэсний дараа “эрхлэх асуудлынхаа хүрээнд” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд кнопоо дараарай. Жавхлан гишүүн.

Б.Жавхлан: Тэгээд 7 сарын 25-нд яамнууд тэр тоонуудаа нэгтгээд, Сангийн яаманд ирүүлнэ. Хязгаартаа багтаагаад. Тэр ер нь хэзээ ч хязгаартаа багтааж ирүүлдэггүй. Энэ дээр нэлээн хэлэлцүүлэг болно. Ингээд 8 сарын 15-нд Сангийн яамнаас Засгийн газартаа танилцуулаад, 27 хоногийн дотор 2 хэлэлцүүлэг хийнэ. Засгийн газрын яг ээлжит хуралдаанаар хийе гэвэл. Тэгээд ээлжит бус байх юм бол 3 байна уу, 4 удаа хэлэлцээд л бүтэн жилийн төсөв шүү дээ. Бүтэн жилийн төлөвлөгөөг санхүүжүүлэх төсвөө ингээд ерөөсөө Засгийн газар хоёрхон 7 хоногийн дотор хэлэлцээд, ингээд 9 сарын 1-нд өргөн барих ийм л цаглавартай болчихож байгаа юм. Хэрвээ энийг жоохон төлөвлөх хугацааг нь Засгийн газарт бас алдаа мадаггүй төрийн албан хаагч нар ид ажлаа хийгээд, ийм нягтрал сайтай үед нь хийе гэвэл энэ наадмаа 6 сарын 10, 11-нд хийдэг болчихвол бүр гоё. Манайхан Наадам, Цагаан сар гэдэг 2 хугацаатай учраас наадмаа татвал энэ 10 сарын 1-ийг 9 сарын 1 хүртэл татаж болох юм байна гэсэн ийм л би санааг хэлэх гэсэн юм. Тэгэхдээ тэр бол хэзээ ч биелэхгүй л дээ. Тийм учраас энэ цаг хугацаа маань бас яг амьдрал дээрээ хэрэгжих боломжгүй л ийм юм болчихоод байгаа юм шүү. Тэгээд ганцхан бас Их Хурал талаасаа харах биш, Их Хурал өөрөө Засгийн газраа ингээд батлаад, төлөвлөгөөг нь батлаад явж байгаа үед яг төлөвлөх шатад нь хугацаагаар нь ингэж шахмааргүй байгаа юм. Энэ бол хэн нэгэн хүний Засгийн газар биш. Энэ чинь Монгол Улсын Засгийн газар. Цаашдаа энэ чинь маш олон Засгийн газар, маш олон цаг хугацаа дээр илүү олон янзын бүрэлдэхүүнтэй Их Хурал ингээд л явдгаараа явна.

Тэгэхээр энэ цаг хугацааны цаглаварыг бол маш олон жилийн өнгөрсөн түүх, туршлага, практик, үр дүн юман дээр суурилж хараад, цаашдаа хэдэн жил явах вэ, энэ нь хэдий урт настай байх вэ гээд маш их сайн хэлэлцүүлэг хийж байж өргөн баривал яасан юм бэ. Энийг албан ёсоор Засгийн газраас бол санал аваагүй. Би өргөн барьсных нь дараа нь л авч үзлээ. Засгийн газрын гишүүдээс иймэрхүү юм болж байна гэж хэлээд хэн ч энийг хэлэлцээгүй. Хэн ч бид нар дээр ерөөсөө ярилцаагүй. Би цаглавар гэхээр нь Сангийн яамыг чинь одоогоор би төлөөлж байгаа хэвээрээ. Сангийн яамнаас албан ёсны санал авъя гэвэл надаар л дамжина. Тэгэхдээ Булгантуяа сайд аа, та өөрөө Сангийн сайд байсан хүн бас хүндэтгэлтэй хандаад, энэ чинь яг явж явж амьдрал дээр Сангийн яамны л ажлыг цаглаварт оруулж байгаа учраас үгүй ээ, 9 сарын 1-ийг та ингээд бүр гарцаагүй хөдөлгөөнгүй болгочхож байгаа байхгүй юу. Уг нь би 9 сарын 15 гэдгээр санал оруулах гэж байсан юм. Бэлдчихсэн байсан юм. Тэгэхээр наадах чинь 9 сарын 15 биш, 9 сарын 1 гэдгийг нь ингээд түгжихэж байгаа байхгүй юу. 9 сарын 1-нд өргөн бариад, аудит руу, төсвийн тогтвортой байдлын зөвлөл рүү шууд өгөөд, 9 сарын 15-нд бэлэн болгоод, энийгээ Ерөнхий сайд, Их Хурал дээр танилцуулна гээд заачихаар ерөөсөө ямар ч хойшлуулах боломжгүй болчихож байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо энэ чинь эхний хэлэлцүүлэг үү. 2 дахь хэлэлцүүлэг үү. Тэгэхээр одоо энэ чинь Үндсэн хуулиараа ийм шүү дээ. Төсвийг төлөвлөх нь Засгийн газрын үүрэг.../минут дуусав/

Б.Баярбаатар: Би асуулт асууя. Яг өнөөдрийн хуулиар Булгаа дарга аа, хууль санаачлагч аа, Булгантуяа дарга аа, Өнөөдрийн хуулиар чинь 9 сарын 1-нд төсвөө өргөн барьж байгаа биз дээ. Тэгээд энэ өөрчлөгдөөгүй биз дээ. Өнгөрсөн жил бол 9 сарын 1-нд барьсан биз дээ. 1 хэлэлцүүлэг л нэмэгдэж байгаа юм байна шүү дээ. Нөгөө миний түрүүний хэлдэг л юм байна шүү дээ тээ.

2 дугаар зүйлтэй холбоотой гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг:

“35.4.Байнгын хороо хүсэлт гаргасан бол Тамгын газар хуулийн төсөлд дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргах бөгөөд зөвлөмжийг Улсын Их Хурлын нийт гишүүнд хүргүүлсэн байна.”

2/64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг:

“64.1.Улсын Их Хурал төсвийн хүрээний мэдэгдлийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор дараах дөрвөн үе шаттайгаар хэлэлцэж, эцэслэн батална:

64.1.1.нэг дэх хэлэлцүүлэгт төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаарх илтгэлийг Ерөнхий сайд, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг зөвлөлийн дарга тус тус нэгдсэн хуралдаанд танилцуулж, гишүүд илтгэл, дүгнэлттэй холбогдуулан Ерөнхий сайд, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн даргаас асуулт асууж, үг хэлэх;

64.1.2.хоёр дахь хэлэлцүүлгээр Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлж болно. Байнгын хороод гаргасан санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх бөгөөд Байнгын хороод хамтарсан хуралдаанаар хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

64.1.3.нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгийн шатанд Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлэх;

64.1.4.гурав дахь хэлэлцүүлгээр хамтарсан байнгын хороо нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусган, төслийн эцсийн хувилбарыг бэлтгэн танилцуулгын хамт нэгдсэн хуралдаанд оруулах;

64.1.5.нэгдсэн хуралдаанаар гурав дахь хэлэлцүүлгийг явуулахад хамтарсан хуралдааны танилцуулгын талаар гишүүд тайлбар хийж, түүнтэй холбогдуулан асууж болох бөгөөд санал хураалт явуулахгүй. Хамтарсан хуралдаанаас гарсан санал Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэх талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаанд танилцуулна. Төсвийн тусгай шаардлага хангагдаагүй нөхцөл үүссэн тохиолдолд тодорхой асуудлаар чиглэл

өгч, хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулахаар хамтарсан Байнгын хороонд төслийг буцааж болно;

64.1.6.нэгдсэн хуралдааны дөрөв дэх хэлэлцүүлгээр төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг эцэслэн батлах.”

3/69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг:

“69.1.Улсын төсөв /цаашид "төсөв" гэх/-ийн төслийг Улсын Их Хурал намрын ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хэлэлцэж эхлэх ба 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор дараах таван үе шаттайгаар хэлэлцэн батална:

69.1.1.төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг буюу төсвийн төсөлтэй танилцах;

69.1.2.төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг буюу төсвийн төсөл нь энэ хуулийн 70.5-д нийцсэн эсэх талаар санал хураалт явуулах;

69.1.3.төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг буюу төсвийн төсөлд өөрчлөлт оруулах санал, дүгнэлт гаргах;

69.1.4.төсвийн төслийн дөрөв дэх хэлэлцүүлэг буюу төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн үр дүнг танилцуулах;

69.1.5.төсвийн төслийн тав дахь хэлэлцүүлэг буюу төсвийн төслийг эцэслэн батлах.”

4/70 дугаар зүйлийн 70.1, 70.2, 70.3, 70.4 дэх хэсэг:

“70.1.Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн шатанд Төсвийн болон бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, нам, эвслийн бүлэг төсвийн төсөлтэй танилцаж, хуралдаанаар хэлэлцэнэ.

70.2.Байнгын болон дэд хорооны хуралдаанд гишүүд тухайн Байнгын болон дэд хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлнэ.

70.3.Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, нам, эвслийн бүлэг эрхлэх асуудлын хүрээнд төсвийн төслийн талаар танилцуулга боловсруулж, Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

70.4.Төсвийн байнгын хороо энэ хуулийн 70.3-т заасан танилцуулгыг хүлээн авч нэгтгэн, нэгдсэн хуралдаанд танилцуулна.”

5/71 дүгээр зүйлийн 71.2, 71.10 дахь хэсэг:

“71.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн төслийн танилцуулгыг энэ хуулийн 71.1-д заасан эрхлэх асуудлын хүрээг баримтлан Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанд танилцуулна.

71.10.Төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн шатанд гарсан төсвийн санал Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төсвийн зарчмыг баримтлахгүй байх нөхцөлийг үүсгэж болзошгүй гэж үзвэл Засгийн газар энэ талаар нэгдсэн хуралдаанд тайлбар хийж болно.”

6/74 дүгээр зүйлийн 74.3 дахь хэсэг:

“74.3.Төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхэд Ерөнхий сайд, төсвийн ерөнхийлөн захирагч нар, Монгол Улсын Ерөнхий аудитор байлцана.”

3 дугаар зүйлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Рэгдэл. Булгантуяа гишүүн нэр өгсөн юм уу. Булгантуяа гишүүнээр тасаллаа. Дүгэрийн Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: энэ 71.2 дээр үндсэндээ Сангийн сайд, Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанд танилцуулахад байна шүү дээ. Төсвийн төслөө. Тэгэхээр энэ дэд хороо гэдгийг тань задалж бичихгүй бол нөгөө 11 дэд хороогоор чинь явчих юм гээд ойлгогдчих вий дээ. Нэр заагаад тийм тийм дэд хороо гээд бичих нь зөв үү.

Б.Баярбаатар: Би хариулчих уу. Энэ нийтдээ байна шүү дээ. Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах 6 хуулийн төсөл өргөн баригдсан байгаа юм. Энэ 6 хуулийн төслийг нэгтгэх, 1 төсөл болгох ажлын хэсгийг надаар ахлуулаад Их Хурлын даргын захирамж гарчихсан. Манай ажлын хэсэг бол 2 удаа хуралдаад, энэний өмнө бас яг хуралдаад тарж байна. Энэ та бүхэнд танилцуулагдаж байгаа энэ төсөл тодорхой түвшинд техникийн нэлээн засварууд орж байгаа. Үг, үсгийн болон иймэрхүү зүйлүүд. Жишээлбэл энэ дээр нам, эвслийн бүлэг төсвийн төсөлтэй танилцаж, хуралдаанаар хэлэлцэнэ. Заавал нам эвслийн бүлгийг өнөөдөр хуульчлах бол шаардлагагүй гэж үзэж байгаа байхгүй юу. Хэлэлцэж ч болно. Хэлэлцэхгүй ч байж болно гэх мэтчилэн иймэрхүү засваруудыг хийж байгаа. Тэгээд ажлын хэсэг маргааш Төрийн байгуулалтын байнгын хороогоор нэг бүрчлэн асуудлуудаа танилцуулна. Нэлээн олон зарчмын зөрүүтэй саналууд ажлын хэсэг дээр гараад, өнөөдөр санал хураагдаад дэмжигдээд явсан байгаа.

Манай Дэгийн байнгын хороо өнөөдөр Их Хурлын тухай хуультай холбогдуулаад, нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулаад дагаж дэгийн хуулиудыг нь л бид нар Дэгийн байнгын хороо. Тэгэхдээ бид нар Булгантуяа даргын өргөн барьсан хууль бол яг дэгтэй холбоотой хууль учраас дагаж Их Хурлын тухай хууль орж ирж байгаа гэдгийг бас хэлье. Жавхлан гишүүн.

Б.Жавхлан: Байнгын хороон даргаас уучлалт хүсье. Зүгээр энэ шатанд нь болдог юм уу, болдоггүй юм уу. Би Их Хурлын дэд дарга, бас Сангийн дэд сайдаар ажиллаж байсан, энэ хуулийг санаачлагч, ажлын хэсгийн ахлагч, санаачлагч гишүүдийг ахалж байгаа хүний хувьд хүсэлт байна Булгантуяа даргад. Энэ гарцаагүй Засгийн газрын үйл ажиллагаа Улсын Их Хурлаас батлагдсан төлөвлөгөөг биелүүлэхийн төлөө явж байгаа энэ институцийн үйл ажиллагаатай шууд холбоотой. Шууд холбогдоно. Үе үеийн цаашдаа ганцхан 1 удаагийн биш. Тийм учраас энийг яг төлөвлөлтийн шат нь хариуцаж байгаа Засгийн газрын гишүүдийг цуглуулаад Ерөнхий сайдын бас үгийг сонсоод, нэг ингээд өгөөч ээ. Ойрын хугацаанд энэ 7 хоногт хэзээ ч бид цуглаад тантай болон танай цуг

санаачилсан гишүүдтэй уулзаад, зовлон жаргалаа ярилцахад бэлэн байна. Энэ хүсэлтийг хүлээж авна уу.

Б.Баярбаатар: Тэр дотоод зохион байгуулалтын асуудлаа тэгээд хэлэлцэж болно биз дээ. Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Тэр бол асуудал байхгүй ээ. Үнэнийг хэлэхэд бол энэ дээр төсвийн хүрээг бол Эдийн засаг, хөгжлийн яам оруулдаг. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Энх-Амгалан дарга манай ажлын хэсэгт орж ажилласан. Дээрээс нь нэмээд Сангийн яамнаас ч гэсэн нэлээдгүй хүмүүс бас орж ажилласан юм. Тэгээд үнэнийг хэлэхэд өмнө нь батлагдчихсан хуулийн 9 сарын 1 гэдгийг бол бид нар хөндөөгүй шүү дээ. Сая бол Төсвийн байнгын хороо дээр энэ хуулийг зүйл заалт болгоноор санал хураалт явуулсан. Тэр дээр бол Улсын Их Хурлын гишүүд бол хуучин ялангуяа энэ хуулийг батлалцсан гишүүд бол 9 сарын 1 гэдгийг бол хөндөхгүй шүү. Харин чуулганыг 9 сарын 15-нд эхлүүлдгийг нь болиод, 10 сарын 1-ээрээ байя гэдэг юмыг ярьсан юм. Тэгээд би бол яг үнэнийг хэлэхэд энэ парламент чинь маш олон шинэ гишүүдтэй, төсвийн асуудал дээр нийгэм, эдийн засаг хүнд байгаа энэ цаг үед онцгой ач холбогдол өгч байгаа юм чинь нөгөө албан бус сонссон танилцуулгаа албан ёсоор сонсож аваад өөрсдөө итгэл үнэмшилтэй болоод тойргоороо явж хэлэлцүүлгүүдийг хийе л гэдэг ийм л ухагдахуунаар бол хийж байгаа юм. Тэгээд манай Баярбаатар дарга бас нөгөө хуулиудыг нэгтгэхдээ ялангуяа найруулгынх нь юунууд дээр нь ажиллаад, нөгөө Байнгын хороод бас зөөчхөж байгаа учраас бас үүнийгээ дагаад дэд хороод гэх юм бол бас нээрээ хэтэрхий өргөн цар хүрээтэй болчихож магадгүй. 1 дүгээрт.

Тэгээд би бол асуудал байхгүй ээ Жавхлан сайд аа, би үүний зовлонг бол мэдэж байгаа шүү дээ. Өнгөрсөн намар, өнгөрсөн жил энийг батлуулж байхад үгүй ээ, энэ ч хэцүү л юм даа гэдгийг чинь. Үгүй ээ, тэгээд яах юм бэ. Баталчихсан хууль дээр чинь л би ажиллаж байна шүү дээ. Ямар юмны өөр зорилготой байх вэ дээ. Тэгэхээр би зүгээр 9 сарын 15 гэдэг дээр манай Дондогмаа дарга би энэ жилийн 9 сарын 15 гэсэн чинь ийм болчих гээд байгаа юм байна. Хагас сайн өдөр таарах гээд байгаа юм байна. Тэгэхээр ажлын өдөр биш, амралтын өдөр таарвал яах вэ гэдэг 1 асуудал байгаа юм байна.

2 дугаарт сая Тамгын газрынхан надад орж ирж танилцуулаад, энэ жил Байнгын ажиллагаатай парламент үүсгэн байгуулагдсаны 35 жилийн ой гээд 9 сарын 13-нд бид нар хүндэтгэлийн чуулган угаасаа хийх юм байна. Ингээд зарим АИХ-ын депутатуудаас УБХ-ын тухайн үеийн гишүүдээс хэрвээ та нар 9 сарын 15-нд эхлэх гэж байгаа бол бүр байнгын ажиллагаатай парламент анх үүсгэн байгуулагдсан өдөр 9 сарынхаа 13-аас ингээд хэлэлцчихэж, 2 хоногийн л хуралдааны чуулганы асуудал байхгүй юу. Тэгэхээр хэлэлцээд эхэлчхэж болдоггүй юм уу гэдэг асуудлыг бас ярьж байна лээ. Яагаад гэвэл хүссэн, хүсээгүй бид нар бол ингээд 5 жил тутамд бол баярын хурал, хүндэтгэлийн чуулган бол хийх л юм байна. Угаасаа энэ цаг үед бол.

Б.Баярбаатар: 3 дугаар зүйлээс асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн “дүгнэлт болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээг” гэснийг “зөвлөмжийг” гэж, мөн зүйлийн 35.8.4 дэх заалтын

“дүгнэлт болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээ хийсэн бол тэдгээрийг тус бүр” гэснийг “зөвлөмж гаргасан бол түүнийг” гэж, 35.8.5 дахь заалтын “дүгнэлт болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээтэй холбогдуулан тус бүр” гэснийг “зөвлөмжтэй холбогдуулан” гэж, 35.15.3 дахь заалтын “дүгнэлт болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээний” гэснийг “зөвлөмжийн” гэж, 39 дүгээр зүйлийн 39.29, 39.31 дэх хэсэг, мөн зүйлийн 39.33.2 дахь заалтын “дүгнэлт” гэснийг “зөвлөмж” гэж, мөн зүйлийн 39.30 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь заалтын “дүгнэлтийг” гэснийг “зөвлөмжийг” гэж, 70 дугаар зүйлийн гарчгийн “нэг дэх” гэснийг “хоёр дахь” гэж, мөн зүйлийн 70.5 дахь хэсгийн “Улсын Их Хурал энэ зүйлд заасны дагуу асуулт асууж, үг хэлсний” гэснийг “Нэгдсэн хуралдаанд Төсвийн байнгын хороо танилцуулга хийсний” гэж, мөн зүйлийн 70.6 дахь хэсэг, 71 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 71.7, 71.11, 71.14 дэх хэсэг, 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн “хоёр” гэснийг “гурав” гэж, 72 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 72.1, 72.2 дахь хэсгийн “гурав дахь” гэснийг “дөрөв дэх” гэж, мөн зүйлийн 72.3 дахь хэсгийн “дөрөв дэх” гэснийг “тав дахь” гэж, 72.4 дэх хэсгийн “гурав, дөрөв дэх” гэснийг “дөрөв, тав дахь” гэж, 73 дугаар зүйлийн гарчгийн “дөрөв дэх” гэснийг “тав дахь” гэж, 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсгийн “Улсын төсвийн гүйцэтгэл” гэснийг “нэгдсэн төсвийн гүйцэтгэл” гэж, мөн зүйлийн 74.4.1 дэх заалтын “аудитын дүгнэлтийг” гэснийг “Төрийн аудитын төв байгууллагын дүгнэлт, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг” гэж, мөн зүйлийн 74.6 дахь хэсгийн “улсын төсвийн орлого, зарлагын нийт дүнг тусгасан Улсын төсвийн гүйцэтгэл” гэснийг “нэгдсэн төсвийн орлого, зарлагын нийт дүнг тусгасан нэгдсэн төсвийн гүйцэтгэл” гэж, 74.7 дахь хэсгийн “Улсын” гэснийг “нэгдсэн” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

5 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйл, 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.13 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Алга байна.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

6 дугаар зүйлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Алга байна.

7 дугаар зүйл. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1, 74.6, 74.7 дахь хэсэгт орсон өөрчлөлтийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

7 дугаар зүйлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. 2027 оны 4 дүгээр зүйлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 74.1, 74.6 74.7 дахь хэсэгт орсон өөрчлөлт.

7 дугаар зүйлтэй холбоотой асуулт, үг гишүүн байна уу. Энэ нөгөө “улсын” гэснийг “нэгдсэн” гэсэн үгний өөрчлөлт явж байна шүү. Асуулт, санал алга байна. Энэ батлагдсан өдрөөсөө явж байгаа. Сая 6 дугаар зүйл дээр байсан.

Дараагийн хууль руу орно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “10 дугаар сарын 01-ний” гэснийг “9 дүгээр сарын 15-ны” гэж, 22 дугаар зүйлийн 22.3.9 дэх заалтын “дүгнэлт болон тэдгээрийг биелүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар дүн шинжилгээ хийлгэх” гэснийг “зөвлөмж гаргуулах” гэж, мөн зүйлийн 22.4 дэх хэсгийн “дүгнэлт, дүн шинжилгээг” гэснийг “зөвлөмжийг” гэж, 46 дугаар зүйлийн 46.5.5 дахь заалтын “дүгнэлт” гэснийг “зөвлөмж” гэж, 48 дугаар зүйлийн 48.1.14 дэх заалтын “дүгнэлт, дүн шинжилгээ” гэснийг “зөвлөмж” гэж тус тус өөрчилсүгэй.

1 дүгээр зүйлтэй холбоотой асуулт саналтай гишүүд байна уу. Алга байна.

Энэ ер нь бол нөгөө Их хурлын Тамгын газрын дүгнэлт гаргана гэдэг маань өнгөрсөн хугацаанд нэлээн бас шүүмжлэл дагуулсан учраас бүх хууль дээрээс зөвлөмж болгож өөрчилж байгаа шүү.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйлтэй холбоотой асуулт саналтай гишүүд байна уу. Алга байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 22.1.2, 22.1.3-т заасан асуудлаар Тамгын газар” гэснийг “Тогтвортой байдлын зөвлөл энэ хуулийн 22.1-д заасан асуудлаар” гэж, 24 дүгээр зүйлийн 24.2, 24.3, 24.4 дэх хэсгийн “Тамгын газрын төсвийн хяналт, шинжилгээний асуудал хариуцсан нэгж” гэснийг “Тогтвортой байдлын Зөвлөл” гэж тус тус өөрчилсүгэй.

1 дүгээр зүйлтэй холбоотой асуулт саналтай гишүүд байна уу. Алга байна.

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтын “Төсвийн тогтвортой байдлын зөвлөл” гэснийг хассугай.

2 дугаар зүйлтэй холбоотой асуулт, саналтай гишүүд байна уу. Алга байна.

3 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

3 дугаар зүйлтэй холбоотой асуулт, саналтай гишүүд алга байна.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйлтэй холбоотой асуулт, саналтай гишүүд байна уу. Алга байна.

Дараагийн хууль.

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтын “Улсын Их Хуралд” гэсний дараа “, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд” гэж нэмсүгэй.

1 дүгээр зүйлтэй холбоотой асуулт, саналтай гишүүд байна уу. Алга байна.

2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын “өргөн мэдүүлэх” гэснийг “өргөн мэдүүлж, мөн хугацаанд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд хүргүүлэх” гэж, мөн зүйлийн 8.4.5 дахь заалтын “байгууллагад” гэснийг “байгууллага, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд” гэж, 8.4.7 дахь заалтын “25-нд” гэснийг “15-нд” гэж, 8.4.8 дахь заалтын “20-нд” гэснийг “15-нд” гэж, мөн зүйлийн 8.10.4 дэх заалтын “улсын төсвийн” гэснийг “нэгдсэн төсвийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйлтэй холбоотой асуулт, саналтай гишүүд алга байна.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

3 дугаар зүйлтэй холбоотой асуулт саналтай гишүүд алга байна.

4 дүгээр зүйл.Энэ хуулийн 2 дугаар зүйлийн дагуу Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалтад орсон өөрчлөлтийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Асуулт, саналтай гишүүд алга байна.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹ дүгээр зүйлийн 16¹.5.2 дахь заалтын “22.1-д” гэснийг “23.1-д” гэж өөрчилсүгэй.

Асуулт, саналтай гишүүд байна уу. 1 дүгээр зүйлтэй холбогдуулж алга байна.

2 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹ дүгээр зүйлийн 16¹.5.3 дахь заалтын “Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан,” гэснийг хассугай.

2 дугаар зүйлтэй холбоотой асуулт, саналтай гишүүд алга байна.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Асуулт, саналтай гишүүд алга байна.

Дараагийн хууль.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “өргөн мэдүүлж,” гэсний дараа “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд хүргүүлнэ.” гэж нэмсүгэй.

1 дүгээр зүйлтэй холбоотой асуулт, саналтай гишүүд алга байна.

2 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийн “өргөн мэдүүлнэ.” гэснийг “өргөн мэдүүлж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд хүргүүлнэ.” гэж өөрчилсүгэй.

Асуулт, саналтай гишүүд алга байна.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Асуулт, саналтай гишүүд алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралд танилцуулна.

18.37 цаг.

4 дэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Хишгээгийн Тэмүүжин нарын 11 гишүүн 2025 оны 6 сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлгийг явуулна. Санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Хишгээгийн Тэмүүжин нарын 11 гишүүн 2025 оны 6 сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Тэмүүжин гишүүн орж ирсэн үү. Тэмүүжин гишүүн ажил давхцаад гарсан учраас танилцуулгыг миний бие хийчихье.

Тэмүүжин нарын 11 гишүүний өргөн мэдүүлсэн хуулийн төсөл байгаа.

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал хадгална. Монгол Улсад засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ хэмээн зааснаар манай Улс байнгын ажиллагаатай нэг танхим, нийтийн танхим бүхий парламентын Бүгд Найрамдах Улс болсон төдийгүй парламентын ардчиллыг Үндсэн хуулиараа тогтоон баталгаажуулсан юм.

Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1-д заасанчлан Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага байна. Ерөнхий сайд нь Улсын Их Хурлаас томилогдож, түүний шууд хяналтад үйл ажиллагаагаа явуулах нь парламентат ёсны гол илэрхийлэл болно.

Парламентын ардчилал нь нээлттэй тэгш, чөлөөт мэтгэлцээн, үзэл бодлын өрсөлдөөнөөр тодорхойлогдох бол парламентат ёс нь парламентаас Ерөнхий сайд томилж, хянаж, хариуцлага тооцоход чиглэдэг билээ. Монгол Улсын Их Хурал 126 гишүүнтэй төрийн эрх барих дээд байгууллага боловч Улсын Их Хурлын чуулганы хуралдааны танхимд Улсын Их Хурлын бүрэлдэхүүнээс гадна Ерөнхий сайдын тусгайлан суудал эзэгнэж хуралдаан даргалагчийн түвшинд танхимын хойморт байрлаж буй нь Үндсэн хуулийн суурь, үзэл баримтлал, Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчимд үл нийцэж байна. Тиймээс парламентын ардчиллыг баталгаажуулахын тулд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны Их Хуралд дахь олонхын ба цөөнхийн тэгш мэтгэлцээнээр явагддаг чуулган, гишүүд сонгогчид иргэдээ төлөөлөн байр сууриа нээлттэй илэрхийлж, дарамт оромжгүй, үгээ чөлөөтэй хэлдэг байхын сацуу хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих Улсын Их Хурлын бүрэн эрх халдашгүй хэрэгжиж, парламентат ёсны үндсэн зарчмыг хамгаалахын тулд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна.

Түүнчлэн төрийн эрх барих дээд байгууллага үйл ажиллагааныхаа алдаа мадаг гаргахгүй үүднээс парламентад худал мэдээлэл өгөхгүй байх, худал мэдээлэл өгөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээдэг байх, олонхын бүлэг буюу түүнээс сонгогдсон Ерөнхий сайдаас асуудаг асуулгын цагийг Улсын Их Хуралд бий болгох, уг асуулга нь нээлттэй тэгш мэтгэлцээний үндсэн дээр өрнөдөг байх зэрэг зарчмын өөрчлөлтийг Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, Төрийн албаны тухай хуульд оруулах шаардлагатай гэж үзлээ. Парламентын нийтийн танхимын гол философи нь засгийн бүх эрх мэдэл ард түмнээс үүдэлтэй гэдгийг бэлгэддэг. Нийтийн танхим дахь суудлын байршил нь олонхын эрх мэдэл ба цөөнхийн хяналт, хариуцлагын илэрхийлэл төдийгүй хуралдаж шийдвэр гаргах

үндсэн зорилгод дээргүй хуралдаж шийдвэр гаргах үндсэн зорилгод зориулагдсан байдаг. Танхимд онцгойрох спикерийн суудал нь хууль тогтоох эрх мэдлийг тэнцвэртэй сонирхлын зөрчилгүй хуралдааны хэлбэрээр хэрэгжүүлэх, үндсэн ажлыг удирдах, зохион байгуулах, хурлын дэгийг сахиулах, парламентын дархлааг хамгаалах үүргийг хариуцан ажиллах байдлыг илтгэдэг. Ардчиллын зарчим буюу хагас дугуй болон дугуй суудлын байрлал нь нам харгалзахгүй хэлэлцүүлэгт уриалан дуудах зорилготой бөгөөд олонх цөөнхийн мэтгэлцээн нээлттэй өрнөх боломжийг хангана. Танхимын байрлал бол зөвхөн архитектур дээр биш улс төрийн соёл, шийдвэр гаргах арга барилд шууд нөлөөлдөг байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны танхим нь улс төрийн чөлөөт өрсөлдөөн мэтгэлцээний талбар байх зарчмыг тэр бүр хангадаггүй. Тэр байтугай чуулганы хуралдааны танхимын зохион байгуулалтын бүдүүвч зураг байршлын ямар субъект батлах талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Тиймээс 1992 оноос хойш Улсын Их Хурлын дэд дарга сайн дураар уг зураглал байршлыг баталж ирсэн. Хамгийн сүүлд Улсын Их Хурлын дэд дарга Хүрэлбаатарын Булгантуяа баталсан нь одоо мөрдөгдөж байгаа ажээ. Тиймээс уг асуудлыг цэгцлэх үүднээс Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах практик шаардлага гэж үзлээ. Хуулийн төслийг дагалдан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж хамтад нь өргөн мэдүүллээ. Танилцуулгыг уншиж танилцууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.3-д 1 хуулийн төслийг хэд хэдэн Байнгын хороо хэлэлцэж, санал, дүгнэлт гаргахаар хууль тогтоомжид заасан бол тэдгээр хуралдаанаа тус тусдаа зохион байгуулж, санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ гэж заасан.

Хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрөөтэй санал ирээгүй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

Зөвхөн дэгийн хуулийг бид хэлэлцэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.17 дахь хэсгийн "Монгол" гэсний өмнө "Ерөнхийлөгчийн мэдээлэл" гэж нэмсүгэй.

1 дүгээр зүйлтэй холбоотой асуулт, үг хэлэх гишүүд байна уу. Алга байна.

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/112 дугаар зүйл. Улсын Их Хурлын асуулгын цаг

“112.1.Ээлжит чуулганы хугацаанд сар бүрийн сүүлийн долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаан Улсын Их Хурлын гишүүдээс Ерөнхий сайдад хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний биелэлт, улс орны эдийн засаг, нийгэм, санхүүгийн төлөв байдал болон бусад асуудлаар тавих Улсын Их Хурлын асуулгын цаг байна.

112.2.Улсын Их Хурлын гишүүд Ерөнхий сайдад тавих асуултаа асуулга болохоос 7 хоногийн өмнө Улсын Их Хурлын даргад бичгээр хүргүүлэх бөгөөд ирүүлсэн асуултыг нэгтгэн Улсын Их Хурлын дарга Ерөнхий сайдад ажлын 2 өдрийн дотор хүргүүлж, асуултыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулна.

112.3.Улсын Их Хурлын асуулга, түүнд өгөх Ерөнхий сайдын хариултыг Байнгын хороодын хуралдаанаар урьдчилан хэлэлцэхгүй.

112.4.Улсын Их Хурлын асуулгын цагт Ерөнхий сайд өөрөө биеэр хариулт өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд холбогдох Засгийн газрын гишүүн нэмэлт хариулт өгч болно.

112.5.Улсын Их Хурлын асуулгын нийт хугацаа 2 цагаас хэтрэхгүй. Ерөнхий сайдаас асуулт асууж, хариулт авах цөөнхийн бүлгийн хугацаа 75 минутаас, олонхын бүлэг 15 минутаас, цөөнхийн гишүүд 30 минутаас хэтрэхгүй байна.

112.6.Цөөнхийн бүлэгт оногдсон хугацааны хоёрны нэг хүртэлх хугацааг тухайн бүлгийн дарга, эсхүл бүлгээс томилогдсон гишүүний цуварсан асуултаар эхлүүлж, мэтгэлцүүлнэ. Үлдсэн хугацаанд цөөнхийн бүлгийн бусад гишүүн асуулт асууж, хариулт авна.

112.7.Энэ хуулийн 112.6-д заасан бүлгийн цуварсан асуултын тоог 9-өөс хэтрүүлэхгүй байна.

112.8. Ерөнхий сайдаас асуулт асуух, үг хэлэх хугацаа 2 минутаас хэтрэхгүй, 1 удаа 1 минутаас хэтрэхгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, үг хэлж болно. Хариулт өгөх хугацаа 2 минутаас хэтрэхгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 1 удаа 1 минутаас хэтрэхгүй байна.

112.9.Асуулт, хариултыг тусгайлан бэлтгэсэн индрээс асууж, хариулна.

112.10.Цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудлаар Ерөнхий сайд Улсын Их Хуралд мэдээлэл хийх шаардлагатай гэж үзвэл энэ зүйлд зааснаас өөр цаг, өдөрт хийж болно. Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан гишүүн асуулт асуух, үг хэлэхэд энэ хуулийн 9.17-д заасныг баримтална.”

2 дугаар зүйлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Алга байна.

3 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.8 дахь хэсгийн "Ерөнхий сайдын мэдээллийн" гэснийг Улсын Их Хурлын асуулгын" гэж, АРВАН ГУРАВДУГААР БҮЛГИЙН гарчгийн "ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ," гэснийг “УЛСЫН ИХ ХУРЛЫН АСУУЛГА," гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйлтэй холбоотой асуулт, саналтай гишүүд алга байна.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

Асуулт, саналтай гишүүд алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Ёс зүйн дэгийн Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ. Төрийн байгуулалт. Очирбатаар нь нэгмөсөн явчихдаг юм уу даа. Очирбат Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. 4 дэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

18.47 цаг.

5 дахь асуудалдаа орно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа нарын 9 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэллээ.

Ариунзаяа гишүүн орж ирж байна. Ариунзаяа гишүүн танилцуулгыг хийнэ. Ариунзаяа гишүүний микрофоныг өгье.

А.Ариунзаяа: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хуралд суудалтай 5 намын төлөөлөл болсон 9 Улсын Их Хурлын гишүүн хамтдаа Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж өргөн барьсан.

Энэ хууль ер нь байнгын ажиллагаатай парламент байгуулагдсанаас хойших энэ хугацаанд ойролцоо 7-8 Байнгын хороо тогтмол, байнгын үйл ажиллагаа явуулсан. Энэ түүхэндээ 2004-2006 онд 2 жилийн хугацаанд 11 Байнгын хороотой

үйл ажиллагаа явуулж байсан түүхтэй. Түүнээс хойш эргээд үндсэн 7, 8 Байнгын хороондоо орж байгаад, 2020 онд дахин эдгээр 3 Байнгын хороо нэмэгдсэн ийм түүхтэй байдаг. Тэгээд яг одоо Улсын Их Хуралд байгаа 11 Байнгын хорооны үйл ажиллагааг аваад үзэхэд хуулиар тогтоосон гишүүдийн дээд хязгаар буюу 25 хүнтэй байх энэ хязгаартаа 3 л Байнгын хороо хүрч байгаа. Зарим Байнгын хороо буюу жишээлбэл манай Байнгын хороо 12 хүнтэй. Тэгээд хуулиар тогтоосон энэ 25 хүнийхээ 50 хувьд нь ч хүрдэггүй. Ажлын ачаалал ч гэсэн бас харьцангуй өөр өөр байгаад байгаа. Ажлын чиг үүргийн давхардал ч гэсэн нэлээдгүй харагддаг. Тэгээд бидний өнөөдрийн бас хэлэлцэж байгаа асуудлуудтай ч гэсэн холбоотой чиг үүргийн давхардал нь нэлээдгүй ажиглагдаж байгаа учраас үүн дээр эргүүлэн үндсэн 7-8 байнгын хороонд иргэн шилжье. Ер нь энэ чиг үүргийн оновчтой байдлыг илүү ухаалаг цомхон байх төрийг Улсын Их Хурал өөрөө манлайлан бас хэрэгжүүлэх хэрэгтэй гэдэг үүднээс 11 Байнгын хороог 8 Байнгын хороо болгож буулгахаар өөрчлөлтийг оруулсан.

Ингэхдээ Аж үйлдвэржилтийн бодлогын болон Инновац, цахим бодлогын байнгын хороог Эдийн засгийн байнгын хороонд нэгтгэх, БСШУС-ын байнгын хороог Нийгмийн бодлогын байнгын хороонд нэгтгэх, Ёс зүй, дэгийн байнгын хороог буюу манай Байнгын хороог Төрийн байгуулалтын байнгын хороонд нийлүүлэх ийм өөрчлөлтийг оруулж байгаа.

Мөн түүнчлэн иргэдээс ирж байгаа саналуудыг нэгтгэх, судлах, дүн шинжилгээ хийх, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар илүү боловсронгуй дүгнэлтүүдийг гаргаж байх. Өргөдлийн байнгын хороог сэргээх гэсэн ийм өөрчлөлтийг оруулж байна.

Төрийн байгуулалтын байнгын хороонд бол Ёс зүйн бүсчилсэн хөгжлийн дэд хороо байгуулахаар, Эдийн засгийн байнгын хороонд ЖДҮ-лэлийн хөгжлийн, Инновац, цахим бодлогын дэд хороог байгуулахаар, БОХХАА-н байнгын хороонд Агаар орчны бохирдлын, ХХАА-н дэд хороо байгуулахаар, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх шинжлэх ухааны байнгын хороонд шинжлэх ухааны соёл, спорт, залуучуудын дэд хороог байгуулахаар хуулийн төслийг боловсруулсан юм.

Ингээд энэхүү Улсын Их Хурлын тухай хууль өөрчлөгдсөнөөр Байнгын хороодын нэр болон тоо өөрчлөгдөж байгаа. Дэд хороод бас нэмэгдэж байгаатай холбогдуулан Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд бас өөрчлөлт оруулахаар байгаа юм. Тэгээд энэ дагасан Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн өөрчлөлтийг хэлэлцэн дэмжиж өгнө үү. Баярлалаа.

Б.Баярбаатар: Баярлалаа. Бид бол Ариунзаяа нарын гишүүдийн өргөн барьсан Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс дагалдаж орж байгаа чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэнэ. Би зүйл бүрээр нь уншиж, танилцуулж, асуулт санал явна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15.10 дахь хэсгийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн, 16.2 дахь хэсгийн,

28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн, 115 дугаар зүйлийн 115.2.14 дэх заалтын “Ёс зүй, дэгийн” гэснийг “Төрийн байгуулалтын” гэж, 95 дугаар зүйлийн 95.2 дахь хэсгийн “39.4-т” гэснийг “39.5-д” гэж, 115 дугаар зүйлийн 115.2.8, 115.2.12, 115.2.16 дахь заалтын “Нийгмийн бодлогын” гэснийг “Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны” гэж тус тус өөрчилсүгэй.

1 дүгээр зүйлээс асуулт саналтай гишүүд нэрээ өгье. Рэгдэл гишүүнээр тасалъя. Рэгдэл гишүүн асуултаа асууна.

Д.Рэгдэл: Тэгэхээр Ариунзаяа гишүүний өргөн барьсан энэ хууль дээр зарчмын зөрүүтэй санал томъёолоод Төрийн байгуулалтын байнгын хороонд өгчихсөн байгаа юм. 2-ыг томъёолоод. Тэрний 1 нь бол энэ дэгийн тухай хуультай холбоотой юм. Энэ дэгийн тухай хуулийн хамгийн сүүлчийн нийгмийн бодлогын гэснийг НББСШУ-ы гэж өөрчилсүгэй гэдгээс шинжлэх ухааны гэдгийг нь хасах санал оруулсан юм. Яагаад вэ гэвэл ерөөсөө шинжлэх ухаан, технологи, инновац, үйлдвэрлэл гэдэг энэ 4 процесс бол нэг тойргоор явдаг процесс. Тийм учраас шинжлэх ухаан, технологи, инновацыгаа 1 дэд хороо болгоод, Эдийн засгийн байнгын хорооны хүрээнд 1 дэд хороо байгуулаад, түүнтэй холбогдсон зүйл заалтын өөрчлөлтийг нь зарчмын зөрүүтэй санал дээр бичээд өгчихсөн.

Тийм учраас энэ НББСШУ-ы гэдэг байнгын хороог нийгмийн бодлого, боловсрол, соёлын, байнгын хороо гэж өөрчилье гэсэн санал өгөөд байгаа. Тэгэхээр учир юунд байна вэ гэхээр бид нар чинь энэ шинжлэх ухаан, технологи, инновац гурваа 1 бол 2 өөр яам дээр байрлуулчихдаг. Нөгөөдүүл нь хоорондоо ерөөсөө яаманд бол хэл амаа ололцдоггүй, ярилцдаггүй. 1 юмыг 2 хуваачихсан. Тэрийг бид нар Их Хурлынхаа түвшинд ядахдаа Эдийн засгийн байнгын хороон дээрээ шинжлэх ухаан, технологи, инновацын гэсэн нэртэй дэд хороотой болж явъя гэсэн л ийм санаа байгаа. Тэгэхээр манай Байнгын хорооны гишүүд миний энэ зарчмын зөрүүтэй саналыг Их Хурал дээр дэмжиж өгөөрэй л гэж хүсэж байгаа юм.

Б.Баярбаатар: Рэгдэл гишүүн санал хэллээ. Тэгэхдээ уг санал нь бол Их Хурлын тухай хуультай холбоотой саналыг хэллээ. Ажлын хэсэг ахалж байгаагийнхаа хувьд би мэдээлэл өгөхөд бол шинжлэх ухааны дэд хороо гэж Нийгмийн бодлогын байнгын хорооны доор байгаа. Энийг Боловсрол, шинжлэх ухааны дэд хороо гэж одоогоор бол Нийгмийн бодлогын байнгын хорооны доор ийм нэртэйгээр дэд хороо бол орчихсон явж байгаа. Тэгэхдээ та зарчмын зөрүүтэй саналаа Төрийн байгуулалтын байнгын хороонд хуулийн хугацаандаа гаргаад өгчихсөн байгаа бол маргааш бид тэрийг 12 цагаас Төрийн байгуулалтын байнгын хороо дээр хэлэлцэж, бас зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна.

Ажлын хэсгээс бас нэг зарчмын зөрүүтэй санал оруулсан байгаа юм. Уг нь та ажлын хэсэгт энэ саналаа гаргаад өгчихсөн бол илүү бараг дээр байсан юм байна даа гэж би харж байна. 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад Хэрлэн гишүүн асуулт асууна гэсэн Хэрлэн гишүүний микрофоныг өгье.

Б.Хэрлэн: Надад 1 зарчмын зөрүүтэй санал байна. Зарчмын зөрүүтэй ч юу байх вэ дээ ерөнхийдөө тэр нөгөө НББСШУБХ гээд тэгээд энэ дээр 23.7.1 дээр боловсрол гэхихсэн тэгээд 23.7.4 дээр мэргэжлийн боловсрол, сургалт гээд тусад нь салгаад авчихсан байгаад байгаа. Тэгэхээр энийг зөвхөн нөгөө 23.7.1 буюу боловсрол гэдгээр нь үлдээх нь дээр юм байна. Яагаад гэвэл нөгөө Боловсролын

ерөнхий хуулийн 7.2-т чинь боловсролын түвшнийг тогтоосон. Энэ боловсролын түвшин дотор чинь нөгөө мэргэжлийн боловсрол гэдэг чинь өөрөө боловсролынхоо тогтолцоондоо ороод, Боловсролын ерөнхий хуулиараа зохицуулагдаад явчихсан байгаа. Тэгэхээр Ерөнхий нэршлээр нь 23.7.1-д зөвхөн боловсрол гэдгийг нь үлдээгээд 23.7.4 буюу мэргэжлийн боловсрол, сургалт гэдгийг нь авах нь зүйтэй юм гэсэн ийм саналыг би хэлэх гээд байгаа юм.

2 дугаарт Рэгдэл академичийн хэлсэнтэй би санал бүрэн нэг байгаа. Тэгэхээр НББСШУБХ гэдгээс шинжлэх ухааны гэдгийг нь аваад Эдийн засгийн байнгын хороо руу нийлүүлэх нь зүйтэй юм. Тэгээд дээр нь Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хороо гээд ингээд инновацыг нь салгаад аваад явчихсан байгаа шүү дээ. Тэгээд энийг ерөнхийдөө Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнд байгуулагдаж байгаа дэд хороонд шинжлэх ухаан, технологи, инновацын дэд хороо гэж оруулах юм бол арай илүү логиктой зөв болох нь гэсэн энэ санааг бол Рэгдэл гуайн энэ санаатай бол бас санал нэг байгаа. Тэгээд энийг цааш нь ажлын хэсэг дээр уламжилж өгнө үү.

Б.Баярбаатар: Их Хурлын тухай хуультай л холбоотой яг асуудлыг бас та хэлчихлээ. Дэгтэй холбоотой биш. Өнөөдөр 13 цагаар зарчмын зөрүүтэй санал гаргах хуулийн хугацаа дуусчихсан. Төрийн байгуулалтын байнгын хороонд. Рэгдэл гуай бол 13 цагаас өмнө бол зарчмын зөрүүтэй саналаа гаргаад өгчихсөн байна. Тийм ээ өгчихсөн юм байна. Тийм тийм тэгэхээр Рэгдэл гуайн санал бол маргааш Байнгын хороон дээр хэлэлцэгдээд явна. Би ажлын хэсэг дээрээ таны энэ саналыг анхаарах гээд оролдъя. Аль болох бид нар зөрүүтэй биш нэгдсэн байдлаар орвол зүгээр байх. Манай ажлын хэсэг Дондогмаа дарга Хэрлэн гишүүний саяын саналыг тэмдэглэж аваад, манай ажлын хэсэгт надад оруулаад өгчихвөл би тэр юун дээрээ бас нэг хараадахъя. Өнөөдөр санал хураагаагүй ч гэсэн бас асуудал юмнуудаа хандаад явчихъя.

Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйлтэй холбоотой асуулт саналтай гишүүд байна уу. Алга байна. Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Ганбатын Очирбат гишүүн.

Очирбат гишүүн ээ, энэ Их Хурлын тухай дэгийн тухай хуульд өөрчлөлт орж байгаа 3 хууль байгаа. Одоо яг 3 дахиа хэлэлцээд дуусаж байна. 3 хуулийн дүгнэлтийг та маргааш 12 цагаас хуралдах Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулчих. 3 дүгнэлт.

2-т байна шүү дээ Байнгын хорооны гишүүддээ мэдээлэл өгье. Нийтдээ би түрүүн хэлсэн. Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 6 хуулийн төсөл өргөн баригдсан. Энэ өнөөдөр нэгтгэгдчихсэн байгаа. 1 хууль болчихсон байгаа шүү. Маргааш бол яах вэ Байнгын хороон дээр та бүхэн бол тус

тусдаа дүгнэлтүүдээ бол танилцуулчихна. Нийтдээ 6 дүгнэлт тэнд танилцуулагдана. Тэндээс дараа нь Төрийн байгуулалтын байнгын хороо дээр санал хураалт явагдуулаад хууль нэгтгэх тухай гэж санал хураалт явуулаад ингээд Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл гээд 1 хуулийн төсөл болоод чуулган руу орно. 1 хуулийн төсөл болоод, тэгээд чуулган руу орно. Тэгээд анхны хэлэлцүүлэг 3 дахь өдөр нэгдсэн чуулганаар хэлэлцэгдэнэ. Тэр дээр зарчмын зөрүүтэй саналуудаа санал хураалгаад, хагалаад эцсийн хэлэлцүүлэг рүү шилжинэ. Эцсийн хэлэлцүүлэг 7 сарын 9 буюу дараагийн 7 хоногийн лхагва гарагт хуралдаж, хууль хоорондын хэлэлцүүлэг хоорондын 7 хоног гэж хуулийн хугацаа байгаа. Энэ 7 хоногоос ирэх 7 хоногт бол чуулган бол завсарлахгүй. Энэ хуулиа батлах үүднээсээ бол дараагийн 7 хоног руу шилжиж лхагва гарагт нь энэ Их Хурлын тухай хуульд орох нэмэлт, өөрчлөлт дэгийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдээ дагалдах хуулиудтайгаа бүгдийг нь батлаад, 7 сарын 9-ний өдөр бол чуулган завсарлана гэсэн ийм хуваарьтай ажиллаж байгаа гэдгийг бас Байнгын хорооны гишүүддээ хэлье.

Ингээд Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны сүүлийн хурал хэлэлцэх асуудлаа дуусаж, өндөрлөлөө.

Хуралдаанд оролцсон Байнгын хорооны нийт гишүүддээ болон хуулийн төслийг танилцуулсан Улсын Их Хурлын дэд дарга Булгантуяа танд талархал илэрхийлье. Хуралдаанд оролцсон ажлын хэсгийн гишүүд, Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлага, албан тушаалтан, ажилтнууд та бүхэндээ бас талархал илэрхийлье. Байнгын хорооны хурал хаасныг мэдэгдье.

19.01 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ